



ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ



JFPR
Japan Fund for Project and
Regional Development



ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ШИНЭЧЛЭН НАЙРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Захиалагч: АХБ-ны Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн
хүчирхийлэлтэй тэмцэх төсөл

Гүйцэтгэсэн: Зөвлөх Др.Б.Түмэндэмбэрэл

Улаанбаатар

2023 он

**Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ,
шаардлагыг тодорхойлох тандан судлах**

I. Удиртгал

II. Монгол Улс дахь гэр бүлийн эрх зүйн харилцааны өнөөгийн байдал

III. Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ, шаардлага

3.1. Гэр бүлийн харилцаа дуусгавар болсны дараах хүүхдийн тэтгэлэг

3.2. Эцэг, эх байх эрхийг хасах болон хязгаарлах асуудал

3.3. Хүн амын удмын сангийн аюулгүй байдал ба гэрлэх нөхцөл

3.4. Гэрлэлтийн гэрээ

3.5. Донор ба тээгч эхийн эрх, үүрэг /Нөхөн үржихүйн туслах аргыг
ашигласны үр дүнд төрсөн хүүхдийн эцэг, эхийг тогтоох/

3.6. Хамтран амьдрагч

IV. Дүгнэлт

I. Удиртгал

Энэхүү судалгааны зорилго нь гэр бүлийн харилцаанд үүсэж буй шинэ хандлага, харилцааг тодорхойлон Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлага буй эсэхийг тандан судлахад оршино.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх хэсэгт “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална.” гэж зааснаар гэр бүлийн гишүүн болох эхнэр, нөхрийн насны хязгаарлалт, нийгэм, соёлын харилцаан дахь эхнэр, нөхрийн оролцоог тодорхойлохын сацуу гэр бүл, эх нялхас, хүүхдийн эрх, ашгийг хамгаалах үүргийг төрд хүлээлгэжээ.

Үндсэн хуулийн энэхүү заалтыг үндэслэл болгон Гэр бүлийн тухай хуулийг 1999 онд баталсан бөгөөд үүнээс хойш нийт 8 удаагийн нэмэлт, өөрчлөлтийг оруулан хэрэгжүүлж байна. Гэвч эдийн засаг, нийгэм, соёлын өөрчлөлтийг дагасан гэр бүлийн харилцааны өөрчлөлтийг бүрэн зохицуулж чадахгүй байна. Жишээлбэл, гэр бүлийн эрх зүй дэх шинэ хандлага болох гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн харилцаа буюу гэрлэгчдийн өмчлөх эрхийн хэлбэрийг харгалзан хуульд тодорхой тусгах, мөн сүүлийн үед дэлгэрч буй хүйс солиулах, тээгч эхийн тусламжтай үр хүүхэдтэй болох, үр шилжүүлэн суулгах, удмын сангийн аюулгүй байдлыг хангах, гэр бүлийн харилцаан дахь хамтран амьдрагчдын эрх зүйн байдлыг тодорхойлох, гэрлэлтийн гэрээнд эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцааг тусгах гэх мэт шинэлэг харилцаа үүсэж байгаа бөгөөд эдгээр харилцааг хууль тогтоомжид нарийвчлан тусгах шаардлагатай байна. Мөн шинээр үүсэж буй гэр бүлийн харилцааг тодорхойлон, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий төрийн байгууллагын чиг үүргийг нарийвчлан тусгах нь хуулийн хэрэгжилтийг хангахад түлхэц үзүүлнэ гэж үзэж байна.

Тус судалгааг ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ыг баримтлан гүйцэтгэсэн бөгөөд дараах дэд сэдвээс бүтнэ. Үүнд:

Нэг. Удиртгал

Хоёр. Монгол Улс дахь гэр бүлийн эрх зүйн харилцааны өнөөгийн байдал

Гурав. Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ, шаардлага

Дөрөв. Дүгнэлт хэсэг хамаарна.

II. Монгол Улс дахь гэр бүлийн эрх зүйн харилцааны өнөөгийн байдал

Гэр бүл гэдэг нь хүний үр удмаа үлдээх, дамжуулах зүй ёсны хэрэгцээгээр аяндаа бий болсон нийгмийн зохион байгуулалтыг ойлгоно.¹ Тодруулбал, гэр бүл гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг /Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэг/ хэлэх бөгөөд гэр бүлийн гишүүн гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүнийг хэлнэ.² Гэр бүл нь удам хоорондын холбоог бий болгосноор нийгмийн суурь болж тухайн гэр бүлд олж авсан хүмүүжил, төлөвшил нь нийгмийн тогтвортой байдлыг хангах суурь болдог. Ийнхүү гэр бүлийн тогтвортой харилцааг хангахад эдийн засаг, нийгэм, улс төр, соёлын олон талт хүчин зүйлсийг харгалзан үзэх хэрэгтэй.

Монгол Улсын Үнсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 16.11 дэх хэсэгт “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална.” хэмээн зааж гэр бүлийн харилцааг тодорхойлон тэдгээрийн хууль ёсны эрх ашгийг баталгаажуулах үүргийг төрд оноожээ. Өөрөөр хэлбэл, төр нь гэр бүл, түүний гишүүд хүсэл зорилготой байх, аюулгүй, сэтгэл тайван амьдрах нийгмийн баталгааг хангах зорилгоор төрийн бодлого, дэг журмыг тогтоох ёстой.

Манай улс дээрх үүргийн хүрээнд 1999 онд Гэр бүлийн тухай хуулийг баталжээ. Тус хуулиар гэрлэлтийн үндсэн нөхцөл, гэрлэх, гэрлэлт дуусгавар болох, түүний үр дагавар, эцэг, эх, хүүхдийн хоорондын харилцаа, тэжээн тэтгэх, тэтгүүлэхтэй холбогдсон харилцаа, хүүхдийг асран хамгаалах, үрчлэхэд холбогдох харилцааг зохицуулах бөгөөд батлагдсанаас хойш 6 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Мөн Монгол Улсад “Төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого 2003 он”, “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого 2016 он”, “Гэр

¹ Н.Лүндээжанцан, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, Адмон Принт, 2023, 239 дэх тал.

² Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэг.

бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийг 2016 онд тус тус батлан мөрдөж байна.

Практикт нийгэм, эдийн засгийн хөгжлөөс хамааран гэр бүлийн хэлбэр, тэдний харилцаа хувьсан өөрчлөгдөж байна. Өөрөөр хэлбэл, гэрлэлтээ батлуулахгүйгээр хамтран амьдрах, гадаадын иргэнтэй гэр бүл болох, гэрлэлт цуцлах, гэр бүлийн маргааныг шийдвэрлэх, гэр бүл дэх хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн тэтгэмжийн асуудал гарсаар байна.

2017 онд 20470 хос гэрлэлтээ бүртгүүлж, 3945 гэр бүл гэрлэлтээ цуцлуулжээ. Гэрлэлт цуцлалтыг гэр бүл байсан хугацаагаар нь авч үзэхэд гэрлэлтээ цуцлуулсан нийт хосын 58.6 хувь нь 10-аас дээш жил, 21.2 хувь нь 7-9 жил, 13.6 хувь нь 4-6 жил, 6.3 хувь нь 1-3 жил, 0.3 хувь нь нэг хүртэл жил хамт амьдарч байсан байна.³

Гэрлэлт цуцлалтын өнөөгийн нөхцөл байдал

Хүснэгт 1. Гэрлэлт, цуцлалтын тоо, улсын дүнгээр

Д/д	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022.11 сарын 25-ны өдрийн байдлаар
	А	1	2	3	4	5	6
1	Гэрлэлт	20556	20386	19940	14353	15879	15901
2	Цуцлалт	3977	4078	4247	3362	3337	4086

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын статистикийн мэдээлэл

Сүүлийн 5 жилд нийт 107.000 хос гэрлэлтээ бүртгүүлсэн. Нарийвчлан үзвэл, 2017, 2018 онуудад 20-21 мянган хос бүртгүүлж байсан бол 2019 оноос гэрлэлт бүртгэлийн тоо буурсан үзүүлэлттэй байна. Харин гэр бүл цуцлалтын тоо жил бүр харилцан адилгүй ч, сүүлийн 5 жилд 23 мянган хос гэрлэлтээ цуцлуулжээ.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын тоон мэдээллийг харвал 2020, 2021 онд гэрлэлт цуцлалт харьцангуй буурсан үзүүлэлттэй байгаа боловч энэ нь Ковид19 цар тахлын тархалттай холбоотой байх магадлал бий. Учир нь 2022 оны 11 сарын 25-ны өдрийн байдлаар 4086 хос гэрлэлтээ цуцлуулсан. Энэ нь гэрлэлт цуцлалт эргээд өсөх хандлагатайг харуулж байна.

³ <https://www.parliament.mn/nn/4822> /Сүүлд үзсэн 2023.05.24./

Хүснэгт 2. Шүүхийн болон захиргааны журмаар гэрлэлт цуцалсан тоо

Үзүүлэлт		М/Д	2017.12 сар /өссөн дүнгээр /	2018.12 сар /өссөн дүнгээр/	2019.12 сар /өссөн дүнгээр/	2020.12 сар /өссөн дүнгээр/	2021.12 сар /өссөн дүнгээр/	2022.11 сар /өссөн дүнгээр/
А		Б	1	2	3	4	5	6
1.Иргэний улсын бүртгэлийн мэдээ								
Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл	Нийт		3977	4078	4247	3362	3337	4086
	Захиргааны журмаар	29	1331	1241	1384	1139	1075	1377
	Шүүхийн журмаар	30	2646	2837	2863	2223	2262	2709


Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын статистикийн мэдээлэл

Гэрлэлт дуусгавар болсон тохиолдлын 1/3 нь захиргааны журмаар, 2/3 хувь нь шүүхийн журмаар гэрлэлт цуцалсан болохыг дээрх хүснэгтээс харж болно.

Сүүлийн 5 жил (2017-2021 он)-ийн хугацаанд Иргэний хэргийн анхан шатны шүүхэд шийдвэрлэсэн нийт 235.907 иргэний хэргийн 9.8% буюу 23.200 хэргийг Гэр бүлийн тухай хуулийн дагуу хянан шийдвэрлэжээ⁴.

Гэр бүлийн эрх зүйн маргааны тоон үзүүлэлтийг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл:

График 1. Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо (2017-2021)




⁴ Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, 7 дахь тал.

Эх сурвалж: ШЕЗ-ийн албан ёсны мэдээлэлд үндэслэсэн ҮСХ-ны мэдээлэл⁵

2017-2021 оны хугацаанд Гэр бүлийн тухай хуулийн дагуу шийдвэрлэсэн хэргийн дундаж үзүүлэлт нэг жилд 4640 байна. Үүнээс 2018 онд хамгийн олон буюу 4763 хэрэг шийдвэрлэсэн бол 2019 онд 4449 болж буурсан ч 2020 онд 4732 болж өсжээ. 2021 онд 2020 оноос 42 хэргээр цөөн буюу 0.9%-иар буурсан үзүүлэлттэй байна. Гэвч 2021 оны байдлаар Иргэний хэргийн анхан шатны шүүхэд Гэр бүлийн тухай хуулийн дагуу шийдвэрлэсэн хэргийн тоо 4690 буюу нийт шийдвэрлэсэн иргэний хэргийн 10.3%-ийг эзэлж байгаа нь сүүлийн 5 жилийн дундаж үзүүлэлт (жилд 4640 хэрэг буюу 9.8%)-тэй харьцуулбал буураагүй гэж үзэж болно.⁶

График 2. Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн төрөл (2016-2021)



Эх сурвалж: ШЕЗ, Монгол Улсын шүүхийн тайлан, 2017-2021 он⁷

⁵ Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, 8 дахь тал.

⁶ Мөн тэнд.

⁷ Мөн тэнд, 10 дахь тал.

Сүүлийн 5 жилийн хугацаа (2017-2021 он)-нд Гэр бүлийн хуулийн дагуу хянан шийдвэрлэсэн хэргийн 60.4 хувь буюу 14021 хэрэг гэрлэлт цуцлах, 25.3 хувь буюу 5879 хэрэг хүүхдийн тэтгэлэг гаргуулах, 8.8 хувь буюу 2057 хэрэг эцэг тогтоох, 0.4 хувь буюу 97 хэрэг эцэг, эх байх эрх хасах, 5.1 хувь буюу 1183 хэрэг нь бусад төрөлд хамаарах гэр бүлийн маргаан эзэлж байна.⁸

2017-2021 онд гэрлэлт цуцалсан хэргийн тоо бусад төрлийн хэргээс их байгаа бөгөөд тус онуудад эцэг тогтоосон хэргийн шүүхийн шийдвэрийн тоон үзүүлэлт жил бүр хэлбэлзсэн байдал ажиглагдав. 2020 онд өмнөх оноосоо 63 хэргээр, 2021 онд өмнөх оноосоо 71 хэргээр буюу 17.6% хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Эцэг, эх байх эрх хасах хэргийн хувьд 2017-2021 онд хэлбэлзсэн шинжтэй, 2018 онд өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байх боловч 2019 онд дахин өссөн байна. 2020, 2021 онуудад буурсан үзүүлэлттэй боловч энэ төрлийн хэргийн тоо бусад төрлөөс хамгийн цөөн хэвээр байна.

Хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэргийн хувьд 2020 онд өмнөх оноос 286 хэргээр буюу 27.3%-иар өссөн бөгөөд 2021 онд өмнөх оноос бага зэрэг буурсан үзүүлэлттэй байна.⁹

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс 2019 онд Монгол гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлтийн судалгаагаар гэр бүлийн харилцааны өөрчлөлт, өнөөгийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох зорилгоор 10 аймаг, 30 сум, нийслэлийн 9 дүүргийн 2016 өрхийг хамруулан гэр бүлийн суурь судалгааг хийсэн байна. Үүнээс үзэхэд судалгаанд хамрагдсан өрхүүдийн маргаан нь мөнгө санхүүгээс үүдэлтэй (41.4%), согтууруулах ундааны хэрэглээнээс (15.7%), хүүхдийн асуудлаар (15.3%), өр зээл (13.9%), үзэл бодлын зөрчлөөс (11%) үүсэж байна. Үүсэж байгаа зөрчил, маргааныг гэр бүлийн гишүүдээр нь харьцуулахад ихэвчлэн эхнэр-нөхрийн

⁸ Мөн тэнд,

⁹ Мөн тэнд 11 дэх тал. Энэхүү шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний мэдээллийг "Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ" судалгаанаас авсан болно.

хооронд (79,9%), эцэг, эх болон хүүхдүүд (19.1%), хадам хүргэн, бэрүүдийн хоорондын харилцаа (7.1%) зонхилж байна.¹⁰

Дээрх маргааны улмаас гэр бүл цуцлах, гэр бүлийн гишүүд хоорондын хэвийн бус харилцаа үүсэж байгаа бөгөөд иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, гэр бүл болоход бэлтгэх, гэр бүлийн харилцаанд хүүхдийн эрхийг хамгаалах, гэр бүлийн эдийн засгийн бие даасан байдлыг хангах гэх зэрэг олон олон арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Иймд хүн амын нийгмийн амьдралын хэв маяг, өөрчлөлтөд нийцүүлэн гэр бүлийн харилцаанд тулгамдаад буй асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй.

¹⁰ Монгол гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт, Судалгааны тайлан. УБ, 2019.

III. Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ, шаардлага

Сүүлийн жилүүдэд Монгол өрх, гэр бүлийн хэв маягт өөрчлөлт орж нийлмэл, дан, өрөөсгөл, дахин гэрлэсэн, дагавар хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй, улс дамнасан, олон соёлт, ижил хүйстэн, хамтран амьдрах, бүлгээр амьдрах¹¹ гэх зэрэг гэр бүлийн маш олон хэлбэрүүд бий болсноор цөөнгүй асуудал үүсэж байна.

Иймд Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зорилгоор дараах асуудлуудыг онцгойлон авч үзэв. Үүнд:

- Гэр бүлийн харилцаа дуусгавар болсны дараах хүүхдийнтэтгэлэг
- Эцэг, эх байх эрх хассан болон хязгаарласан тохиолдол
- Хүн амын удмын сангийн аюулгүй байдал ба гэрлэх нөхцөл
- Гэрлэлтийн гэрээ
- Донор ба тээгч эхийн эрх, үүрэг
- Хамтран амьдрагчийн эрх зүйн зохицуулалт

3.1. Гэр бүлийн харилцаа дуусгавар болсны дараа эцэг, эх хүүхдэдээ олгох тэтгэлэг

Гэр бүлийн тухай хуулиар эцэг, эх хүүхдээ хүмүүжүүлэхэд тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ гэж хуульчилсан.

Эцэг, эхийн үүрэг	<ul style="list-style-type: none">- хүүхдээ эрүүл чийрэг өсгөн бойжуулах, сэтгэхүйн хувьд төлөвшүүлэх;- хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх;- хүүхдээ үндэсний ёс заншил, уламжлалаа дээдлэх үзлээр хүмүүжүүлэх, түүнд суурь боловсрол эзэмшүүлэх, хөдөлмөрийн анхны дадлага олгох;- хүүхдийн эрхийг хамгаалж, үүргээ биелүүлэхэд нь туслах.
-------------------	--

Мөн тус хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.3-т эцэг, эх нь насанд хүрээгүй, эсхүл хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй бөгөөд тухайн үүргээ биечлэн гүйцэтгэх боломжгүй бол эцэг, эх харилцан тохиролцож гэрээ байгуулан хүүхдэд тэтгэлэг өгнө. Хэрвээ эцэг, эх харилцан тохиролцоонд

¹¹ Доктор Б.Оюун-Эрдэнэ, Гэр бүлийн судалгаа боловсролын хүрээлэн, Монгол гэр бүлийн бүтэц, хэв маяг, харилцааны онцлог, тулгамдаж буй асуудал сэдэвт судалгаа. <https://www.gerbul.mn/378/news.more>

хүрч чадаагүй эсхүл эцэг, эхийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол хүүхдийн тэтгэмжийг шүүх тогтоож, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас гүйцэтгэлийг хангуулна. Тодруулбал, шүүгч гэрлэлт цуцлах тухай шийдвэр гаргахдаа хүүхдийг цаашид хүмүүжүүлэх талаар гэрлэгчдийн хооронд хэлэлцэн тохирсон зүйл байхгүй бол хүүхдийг эцэг буюу эхийн хэний нь асрамжид үлдээх, хамтран өмчлөх дундын өмчийг хуваах, хүүхдийн тэтгэлэг гаргуулах болон орон сууцны маргааны асуудлыг нэхэмжлэлийг үндэслэн хянан шийдвэрлэнэ.

Гэвч Үндэсний статистикийн хорооны мэдээллээр 2021 оны 12 сарын 31-ний байдлаар тэтгэлэг авагч нийт 13.886 хүүхэд байгаагаас 9.739 хүүхэд тэтгэлгээ авч чадаагүй байгаа ба үүнийг мөнгөн дүнгээр тооцвол 6.606.2 сая төгрөг төлөгдөөгүй гэжээ.¹² Өөрөөр хэлбэл, хүүхдийн тэтгэмж олгох тухай шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн 70 гаруй хувь огт төлөгддөггүй байна.

Манай улсын хувьд тэтгүүлэгчийн амьдарч байгаа бүс нутагт тогтоосон амьжиргааны баталгаажих доод түвшингийн хэмжээнээс тодорхой хувиар тооцон тэтгэлгийн хэмжээг тогтоож байгаа нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй харьцуулахад бага, амьжиргааны доод түвшингээс тогтоосон хувь хэмжээгээр тэтгэлгийг тооцоход тэтгүүлэгчийн зайлшгүй шаардлагатай хэрэгцээг бүрэн хангахад хүрэлцэхгүй хэмжээний тэтгэлэг байх тохиолдолд амьжиргааны баталгаажих доод түвшингээс хувь тэнцүүлэх бус тэтгэгчийн цалин орлогоос хувь тэнцүүлэхээр хуульд тусгавал зохистой. Учир нь өндөр орлоготой тэтгэлэг төлөгчийн орлогоос хувь тэнцүүлэн тэтгэлгийг төлүүлэх нь тэтгүүлэгчийн эрх ашигт ч үр өгөөжтэй.

Нөгөөтэйгөөр орлого багатай тэтгэлэг төлөгч нь хуулиар заасан хувь хэмжээгээр тэтгэлэг төлөхөд түүнд санхүүгийн бэрхшээлтэй байдал үүсэхгүй ба энэ тохиолдолд орлогоос хувь тэнцүүлэн тэтгэлгийг гаргуулах нь тэтгэлэг төлөгчийн эрх ашигт нийцэж, талуудын аль алины эрхийг тэнцвэртэй хангахад чиглэсэн гэж үзэж байна.


Дээрхээс дүгнэвэл эцэг, эх хүүхдийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаа бөгөөд энэ нь тухайн харилцааг зохицуулж буй эрх зүйн орчин сул буйгаас тодорхой хэмжээгээр хамааралтай. Тиймээс эцэг, эхийн хүүхдийн өмнө хүлээх

¹² Мэдээлэл https://1212.mn/mn/statistic/statcate/573071/table-view/DT_NSO_2300_043V1

үүргийн гүйцэтгэлд хяналт тавих, хариуцлага хүлээлгэх механизмыг тодорхой болгох, гэр бүл цуцлах тохиолдолд хүүхдийн эрх ашгийг хамгаалах, өмнө нь амьдарч байсан орчин нөхцөлийг дордуулахгүй байх тал дээр анхаарах хэрэгтэй.

Хүүхдийн тэтгэлэг гаргуулах шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж үзвэл, сүүлийн 5 жилийн дундажаас харахад жилд 1175 хүсэлт шүүхээр шийдвэрлэгдсэн байх бөгөөд хүүхдийн тэтгэлэг гаргуулах хүсэлт жил бүр нэмэгдэх хандлагатай байна. Жишээлбэл, 2019 онд 1047 хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэрэг шийдвэрлэж байсан бол 2020 онд 1333 хэрэг, 2021 онд 1297 хэргийг тус тус шийдвэрлэжээ.¹³

График 3. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэргийн тоо (2017-2021)



Эх сурвалж: ШЕЗ, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны дүн мэдээ

2017 оны шүүхийн шийдвэрүүдээс түүвэрлэн, гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргахдаа хүүхдийн тэтгэлэг гаргуулах талаар давхар нэхэмжлээгүй 50 шүүхийн шийдвэрийг судалж үзэхэд, 10 шийдвэрт буюу 20%-д нь хүүхдийн тэтгэлэг гаргуулахаар, 40 шүүхийн шийдвэрт буюу 80%-д нь хүүхдийн тэтгэлгийг огт шийдвэрлээгүй бол 2022 онд энэ үзүүлэлтийн харьцаа 10%-д нь хүүхдийн тэтгэлгийг хамтад нь шийдсэн, 90%-д нь хүүхдийн тэтгэлгийг огт шийдвэрлээгүй дүнтэй байна.¹⁴

¹³ Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, 19 дэх тал.

¹⁴ Мөн тэнд, 19 дэх тал

Гадаад улс орнууд хүүхдийн тэтгэлгийн асуудлыг төрөөс хэрхэн зохицуулдаг талаар

Нэг. ЭСТОНИ УЛС

Гэр бүлийн тухай хуулийн¹⁵ наймдугаар бүлэгт эцэг, эх хүүхдээ тэжээн тэтгэх, тэтгэлэг олгох асуудлын талаар тусгасан бөгөөд тус хуулийн 96 дугаар зүйлд зааснаар бага насны хүүхэд, ахлах болон тусгай мэргэжлийн сургуульд суралцаж байгаа 21 хүртэлх насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эцэг, эхээсээ тэтгэлэг авах эрхтэй. Гэр бүлийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу насанд хүрээгүй хүүхдэд сар бүр олгох тэтгэлгийн хэмжээг ЗГ-аас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиас багагүй байх ёстой.

Хүүхдийн тэтгэмжийг шүүх тогтоох бөгөөд ингэхдээ шүүх Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтоож, үүнийг тогтмол, эсхүл сар бүрийн хэрэгцээний ялгамжтай байдлыг харгалзан хувьсах байдлаар тогтоож болдог.

Хэрэв тэтгэмж төлөх үүрэг бүхий эцэг, эх нь тухайн үүргээс зайлсхийх тохиолдолд хүүхдийн асран хамгаалагч шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандан шүүхийн шийдвэрийг хангуулах боломжтой. Шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хүүхдийн хууль ёсны асран хамгаалагчийн өргөдлийг үндэслэн хариуцагчийн хөрөнгийг битүүмжлэх, дуудлага худалдаанд оруулах гэх мэт албадлагын арга хэмжээг хэрэгжүүлж болох бөгөөд энэ тохиолдолд хүүхдийн тэтгэмж хариуцагчид урьдчилан мэдэгдэх ёстой. Түүнчлэн хүүхдийн тэтгэмжтэй холбоотой шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь бусад төрлийн иргэний нэхэмжлэлээс нэн түрүүнд тавигдах байдлаар хуульчлагдсан нь практикт үр нөлөөтэй хэмээн үзэхээр байна.

Хоёр. БНСУ

БНСУ-ын хувьд гэр бүлийн харилцааг дараах хууль тогтоомжоор зохицуулж байна. Үүнд:

- Гэр бүлийн эрүүл зан үйлийг дэмжих тухай хууль (1990.04.09)
- Эрүүл гэр бүлийн суурь хууль (2001.04.09)

¹⁵ <https://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/84956/94847/F1253520391/EST-84956.pdf> (Сүүлд үзсэн: 12.31нд)

- Гэр бүлд ээлтэй нийгмийн орчныг дэмжих тухай хууль (2001.12.14)
- Ганц бие эцэг, эхийн гэр бүлийг дэмжих тухай хууль (1989.04.01)
- Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэрэгжилтийг хангах, дэмжих тухай хууль (2014.03.24)
- Олон соёлт гэр бүлийг дэмжих тухай хууль (2008.03.21)
- Гэрлэлт зуучлалыг зохицуулах тухай хууль (2007.12.14)
- Хүүхэд харах үйлчилгээг дэмжих тухай хууль (2012.02.01)

Дээрх хууль тогтоомжийн хүрээнд гэр бүл, хүүхдийн эрх ашигтай холбоотой асуудлыг дараах төрийн байгууллагууд хариуцдаг. Үүнд:

- Жендерийн тэгш байдал, гэр бүлийн яам
- Солонгосын эрүүл гэр бүлийг дэмжих газар
- Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн гүйцэтгэлийн хороо
- Олон соёлт гэр бүлийн бодлогын хороо.

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэрэгжилтийг хангах, дэмжих тухай хууль /양육비 이행확보 및 지원에 관한 법률/-ийн 4 дүгээр зүйлд төрөөс хүүхдийг өсгөн хүмүүжүүлэхэд эцэг, эхээс өгөх хүүхдийн тэтгэлгийн зардлын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий байгууллага байгуулж ажиллахаар заасан байх¹⁶ ба энэ хүрээнд Жендерийн тэгш байдал, гэр бүлийн яам нь хүүхдийн тэтгэлгийн гүйцэтгэлд хяналт тавих хүүхдийн тэтгэмжийн гүйцэтгэлийн хороо /양육비이행심의위원회/ ажилладаг байна. Тус хорооны дарга нь тэтгэмжийн үүргээс зайлсхийх тохиолдолд тэтгэмж авах эрх бүхий этгээд нь Гэр бүлийн маргаан хянан шийдвэрлэх тухай хууль /가사소송법/, Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /민사집행법/-ийн дагуу дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ /Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэрэгжилтийг хангах, дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйл/. Үүнд:

- Эд хөрөнгийг тодорхойлох
- Хүүхдийн тэтгэмж ийн албадлагын аргаар гаргуулах

²⁵ Төрөл садан гэдэгт цусан төрлийн 8 үе доторх садан, 4 үе доторх хамаатан, хууль ёсны гэр бүлийн 4촌 이내의 인척, 배우자

- Эд хөрөнгийг барьцаалах

- Эд хөрөнгийг битүүмжлэх хүсэлтийг холбогдох байгууллагад гаргах эрхтэйгээр үйл ажиллагаа явуулна.

Мөн хүүхдийн тэтгэмж төлөгч нь үүргээ биелүүлээгүй, хүүхдийн тэтгэлэг эрсдэлд орох эсвэл эрсдэлд орсон бол Хүүхдэд зориулсан **түр тэтгэлэг буюу яаралтай** тусламж /긴급지원/-ийг Газрын даргаас хүсэж өргөдөл гаргаж болно. Өргөдөл хүлээн авсан газрын дарга холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх бөгөөд тэтгэмжийн хугацааг 6 сараас хэтрэхгүй байхаар тогтоох ба хүүхдийн сайн сайхны төлөө 3 сараар сунгаж болно. Тэтгэлэг хариуцагч нь хүүхдийн тэтгэлэг төлсөн тохиолдолд тусламжийг цуцална. Гэхдээ Газрын дарга яаралтай тусламжийн хүрээнд төлөгдсөн тэтгэмжээ хариуцагчаас нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.

Үүнээс гадна хүүхдийн тэтгэмжийн үүргээс зайлсхийсэн асран хамгаалагчын жолооны үнэмлэхийг хүчингүй болгох /Хуулийн 21 дүгээр зүйлийн 3/, гадаадад зорчих эрхийг хасах /21 дүгээр зүйлийн 4/, хувийн мэдээлэл /овог нэр, нас, эрхэлдэг ажил, мэргэжил, ажлын газрын хаяг, тэтгэмжээс татгалзсан хугацаа, тэтгэмжийн үнийн дүн/-ийг нийтэд ил зарладаг /21 дүгээр зүйлийн 5/ байна.,

Гурав. АВСТРАЛИ УЛС

1975 онд батлагдсан Гэр бүлийн тухай хууль¹⁷ нь гэр бүлийн харилцаанд хүүхэд хүмүүжүүлэхэд эцэг, эхэд тэгш эрх, үүрэг хүлээлгэж, хүүхдийн эрхийг зөрчигдөхөөс хамгаалах зорилгоор батлагдсан байна.

Австрали улсын хувьд хэд хэдэн онцлог зохицуулалттай байна.

Нэг. Гэр бүл цуцалсан тохиолдолд хүүхдийн асран хамгаалагч төлөвлөгөө гаргадаг.¹⁸

Хоёр. Шүүх гэр бүл цуцлах тухай шийдвэр гаргахдаа хүүхэд хэний асрамжид үлдэхээс үл хамаарч эцэг, эх хоёр адил тэнцүү үүрэг, хариуцлага хүлээнэ.

²⁵ Төрөл садан гэдэгт цусан төрлийн 8 үе доторх садан, 4 үе доторх хамаатан, хууль ёсны гэр бүлийн 4 чон 이내의 인적, 배우자

²⁵ Төрөл садан гэдэгт цусан төрлийн 8 үе доторх садан, 4 үе доторх хамаатан, хууль ёсны гэр бүлийн 4 чон 이내의 인적, 배우자

Гурав. Шүүх эцэг, эхийн гаргасан төлөвлөгөөнд үндэслэн хүүхэд өсгөн хүмүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх бөгөөд үүнийг хүүхдийн тэтгэлгийн гэрээ гэж нэрлэдэг.¹⁹

Хүүхдийн тэтгэмжийг Хүүхдийн дэмжлэг (бүртгүүлэх, бүрдүүлэх)-ийн тухай хууль, Хүүхдийн дэмжлэг (үнэлгээ)-ийн тухай хуулиудаар зохицуулдаг. Энэ хоёр хуулийн хүрээнд санхүүгийн дэмжлэгийг хүүхдийн тэтгэлэг хэмээн ойлгоно. Хуулийн хүрээнд Хүүхдийн тусламжийн агентлаг буюу child support agency ажилладаг ба хүүхдийн тэтгэлэгтэй холбоотой асуудлыг тус агентлаг хариуцан ажилладаг.

Дүгнэлт, санал

Хүүхдийн тэтгэмжийн гол онцлог бол хүүхэд өсч бойжих явцад эцэг, эх тэгш эрх, үүрэгтэй оролцох гэр бүлийн харилцааны нэгэн хэлбэр бөгөөд хүүхдийн хууль ёсны тэтгэгч хүүхдэд “материаллаг тусламж” үзүүлэхэд оршино.

Монгол улсын ГБТХ-д энэ харилцааг зохицуулсан байдал нь гадны зарим улсын хууль тогтоомжид тусгасан хүүхдийг тэжээн тэтгэх, асран хамгаалахтай холбоотой хууль тогтоомжтой харьцуулан үзэхэд хүүхдийг тэжээн тэтгэх үүрэг бүхий асран хамгаалагчийн “гэрээ” нийтлэг байдлаар зохицуулагдсан байна.

Иймээс, тэтгэмж олгогчийн эдийн засгийн орлого өсөхийн хэрээр тэтгэмжийн хэмжээ нэмэгдэх бол эсрэгээрээ орлого бага тохиолдолд түүнтэй хувь тэнцүүлэн тэтгэмжийн хэмжээг бууруулан тооцох аргачлалыг тэтгэмжийн хэмжээг индексжүүлэх гэх ухагдахуунаар тодорхойлон томъёолох нь зүйтэй юм. Ингэснээр тэтгэмж төлөгчийн санхүүгийн боломж, тэтгэмж авагчийн эрх ашгийн тэнцвэрт байдлыг хангахад ач холбогдолтой байх юм.

Мөн инфляцын түвшингийн хэлбэлзэл үнийн өсөлтөөс хамаарч тэтгүүлэгчийн зайлшгүй шаардлагатай хэрэгцээг бүрэн хангахад хүрэлцэхгүй байх тохиолдол үүсэх эрсдэлээс сэргийлэх боломжтой юм.

Цаашилбал, хүүхдийн тэтгэлэг эрсдэлд орсон тохиолдолд БНСУ-ын жишгээр төрөөс **түр тэтгэлэг** олгодог аргачлалыг өөрийн улс орны хууль

²⁵ Төрөл садан гэдэгт цусан төрлийн 8 үе доторх садан, 4 үе доторх хамаатан, хууль ёсны гэр бүлийн 4촌 이내의 인적, 배우자

тогтоомжид тохируулан хуульчилбал хүүхдийг эдийн засгийн эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх нэг арга зам болох юм.

3.2. Эцэг эх байх эрх эрхийг хасах болон хязгаарлах асуудал

Гэр бүлийн тухай хуульд зааснаар дараах тохиолдолд шүүх эцэг, эх байх эрхийг хасаж болно /Хуулийн 30 дугаар зүйл/. Үүнд :


- Эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан /хүүхдээ хаях, санаатай төөрүүлэх, тарчлаан зовоох, худалдах, барьцаалах, биеийг нь үнэлэх, шунахай зорилгоор ашиглах, эрх зүйн зөрчилд татан оруулах зэргээр/
- Хүүхэдтэйгээ удаа дараа хэрцгий харьцсан
- Бэлгийн харьцаанд оруулахаар завдсан, оруулсан
- Сэтгэл санааны хүнд дарамтад байлгасан
- Хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргээс санаатайгаар зайлсхийсэн
- Согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг.

Мөн тус хуульд заасны дагуу дараах тохиолдолд эцэг, эх байх эрхийг түр хугацаагаар хязгаарлана /Хуулийн 27 дугаар зүйл/. Үүнд :

- Хүүхдийг орон сууц, хувцас, хоол ундаар байнга санаатай гачигдуулсан
- Хөдөлмөрийг нь зүй бусаар ашигласан, гуйлгачлуулсан
- Орон гэрээсээ дайжуулсан, гадуурхсан.

Ийнхүү хүүхдийн эрхийг зөрчсөн эцэг, эхийн эцэг, эх байх эрхийг түр хязгаарлах, хасах арга хэмжээг эцэг, эх нь, эсхүл төрөл, садангийн хүн, бусад иргэн, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага шүүхэд гаргаж байна. Гэхдээ эцэг, эхэд оногдуулах дээрх арга хэмжээ нь хэр оновчтой эсэх, хэрэгжүүлсэн тохиолдолд хүүхдийн хүчирхийлэл буурах боломжтой эсэхэд дүгнэлт өгөх хэрэгтэй. Жишээлбэл, эцэг, эх байх эрхийг хасах, эрхийг нь түр хязгаарлах эрх зүйн нөхцөл нь агуулгын хувьд нийтлэг шинжтэй байгаа нь тус хуулийн зүйл заалт нь практикт хэрэгжихэд асуудал дагуулахаар байна.

График 4. Эцэг, эх байх эрх хассан хэргийн тоо (2018-2021) он



Эх сурвалж: ШЕЗ, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны дүн мэдээ

Дээрх мэдээллээс харвал, шүүхээс эцэг, эх байх эрхийг хасах тухай шийдвэрийг 2018 онд 2, 2019 онд 6, 2020 онд 3, 2021 онд 5 тус тус гаргасан бол түр хязгаарлах шийдвэрийг 2020 онд 1 удаа гаргаж байжээ. Хүүхэд эцэг, эхийн хамгаалалтад өсөж бойжих эрхтэй хэдий ч эцэг, эхийн дарангуйлал, хүчирхийлэлд өртөж болохгүй бөгөөд энэ тохиолдолд хүүхдийн өмнө хариуцлага хүлээх чадвартай байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, хүүхэд хамгаалах талаар хууль эрх зүй, эдийн засаг, нийгмийн орчинг боловсронгуй болгож хүчирхийлэл үйлдэх болсон шалтгаан нөхцөлийг илрүүлэх, мониторинг хийх түүнд тохирсон арга хэмжээ авах нь зүйтэй.

Гадаад улсын эцэг, эх байх үүрэг хариуцлага болон эцэг, эх байх эрхийг хасах, хязгаарлах талаарх эрх зүйн зохицуулалт

Нэг. ХБНГУ

ХБНГУ-ын Үндсэн хуулийн 1 дэх хэсгийн 6 дугаар зүйлд “гэрлэлт, гэр бүл төрийн хамгаалалтад байна.” хэмээн хуульчилсан байна. “Гэр бүл” гэсэн ойлголт

нь эцэг, эх тэдний хүүхдийн хоорондын харилцааг ойлгох ба энэхүү ойлголтыг Үндсэн хуульд тусгаснаар суурь үнэт зүйлийн илэрхийлэл болдог ажээ.

Гэр бүлийн харилцааг Иргэний хуулийн 4 бүлэгт багтаасан ба эхний 3 бүлэгт “Иргэний гэрлэлт”, “Гэр бүлийн харилцаа”, “Асран хамгаалах” гэсэн харилцааг тус тус зохицуулдаг байна.²⁰

Иргэний хуульд “Эцэг, эхийн халамж хамгаалал” нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих, хүүхдийн бие даах чадварыг харгалзахаар хуульчилсан байна. Тус хуулийн 4 дүгээр бүлгийн 2 дахь хэсгийн 5.1626 дахь зүйлд эцэг, эх насанд хүрээгүй хүүхдээ асран хамгаалах эрх, үүрэгтэй болохыг зааж, эцэг, эхийн асран хамгаалал нь хүүхдээ асран хамгаалахын зэрэгцээ түүний хөрөнгийг мөн адил хамгаална хэмээн тодорхойлжээ.²¹

Иргэний хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 5.1626 дахь зүйлд хүүхдийн хувийн болон өмчийн эрх зөрчигдөн, хүүхэд бие бялдар, сэтгэл гутралд орвол Гэр бүлийн шүүх хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах шаардлагатай арга хэмжээг авах үүрэгтэй. Эцсийн арга хэмжээ нь эцэг, эх байх эрхийг нь хэсэгчлэн болон бүрэн хасах шийдвэр гаргадаг байна. Эцэг, эх асран хамгаалах эрхээ буруугаар ашигласан, хүүхдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хариуцлагатай эцэг, эх байх чадваргүй тохиолдолд эцэг, эх байх эрхийг мөн адил хасдаг.

Үндсэн хуулийн дагуу эцэг, эх байх эрх нь чухал үндсэн эрхийн нэг учраас эцэг, эх байх эрхийг хасах, хязгаарлах асуудалд өндөр босго, шалгуурыг тавьдаг. Хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн байгууллага хүүхдийг гэр бүлээс нь салган өөр гэр бүл, хүмүүс, байгууллагад шилжүүлэхээс өмнө хүүхдийн эрхийн хамгаалалтын талаар нухацтай судалсны үндсэн дээр эцэг, эх байх эрхийг хязгаарлах талаар шийдвэр гаргадаг байна.

Тус улсын Эрүүгийн хуулийн 171 дүгээр зүйлд “Арван зургаан нас хүрээгүй хүүхдээ асран хамгаалах, хүмүүжүүлэх үүргээ эс биелүүлэн түүний бие бялдар,

²⁵ Төрөл садан гэдэгт цусан төрлийн 8 үе доторх садан, 4 үе доторх хамаатан, хууль ёсны гэр бүлийн 4 чон 이내의 인적, 배우자

²⁵ Төрөл садан гэдэгт цусан төрлийн 8 үе доторх садан, 4 үе доторх хамаатан, хууль ёсны гэр бүлийн 4 чон 이내의 인적, 배우자

сэтгэцийн хөгжилд хор учруулах, улмаар түүнийг гэмт хэрэг үйлдэх, биеэ үнэлэхэд хүргэсэн этгээдийг 3 хүртэл жилийн хугацаагаар хорих эсхүл мөнгөн торгууль ногдуулдаг байна.²²

Хоёр. НОРВЕГИ УЛС

Норвеги улсад Хүүхдийн асран хамгаалагчийн буюу эцэг, эхийн хариуцлагын тухай асуудлыг 1981 оны Хүүхдийн тухай хууль /The children act/, 1927 оны Асран хамгаалагчийн тухай хууль /Guardianship act/-д²³ тус тус тусгасан байна. Хүүхдийн асран хамгаалагчийн үүрэг хариуцлагын тухай бие даасан хуультай ч энд зөвхөн хүүхдийн өмнөөс хуулийн байгууллагад хүлээх хариуцлага буюу хүүхдийн гаргасан зүй бус үйлдлийн төлөө хүлээх эцэг, эхийн үүрэг хариуцлагын талаар зохицуулсан байна.

Харин Хүүхдийн тухай хуулийн 5 дугаар бүлэгт асран хамгаалагч гэж эцэг, эх болон хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн түүний ойр дотны хүн гэж тодорхойлсон байдаг бол “хүүхдийн асран хамгаалалт” гэсэн ойлголтод хүүхдийг асран хамгаалах үүрэг ба тэдний төлөө шийдвэр гаргах эрх аль аль нь багтсан байна.

Норвегийн Хүүхдийн тухай хуулийн 30-р зүйлд зааснаар хүүхдийн асран хамгаалагч нь юун түрүүнд түүний эцэг, эх байх бөгөөд хүүхдээ 18 нас хүртэл асран халамжлах үүрэгтэй хэмээн тусгасан байна. Ингэхдээ аливаа шийдвэрийг хүүхдийн хүсэл сонирхолд нийцүүлэн гаргах ёстой гэдгийг мөн хуульд тусгасан.

Норвегид эцэг, эхэд ногдуулах шийтгэлийг хуульд тусгайлан заагаагүй. Харин хэрэг шийдвэрлэсэн жишээ /Case law/-г баримтлан шийтгэл оногдуулах нь нийтлэг байдаг. Эцэг, эх өөрсдийн үүрэг хариуцлагыг ямар ч тохиолдолд ханган биелүүлэх үүрэгтэй боловч тэдний эцэг, эхийн хариуцлагыг цуцлах тохиолдол байдаг.

Энэ нь практиктхоёр тал харилцан тохиролцсон эсхүл шүүхийн шийдвэрт үндэслэн эцэг, эх байх хариуцлагыг цуцална.

²² Төрөл садан гэдэгт цусан төрлийн 8 үе доторх садан, 4 үе доторх хамаатан, хууль ёсны гэр бүлийн 4 чон 이내의 인적, 배우자

²³ Төрөл садан гэдэгт цусан төрлийн 8 үе доторх садан, 4 үе доторх хамаатан, хууль ёсны гэр бүлийн 4 чон 이내의 인적, 배우자

Шүүхийн практикаас үзэхэд, эцэг, эх хүүхэдтэй хамт байх нь хүүхдийн эрх, ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол эцэг, эхийн үүргийг цуцалдаг байна. Жишээлбэл, түүний ерөнхий зан бадал нь хүүхдэд хор хөнөөлтэй (дорд үзэн шоовдорлодог, хүчирхийлдэг, бэлгийн дарамт үзүүлдэг зэрэгт сэжиглэгдсэн) гэж үзэх үндэстэй бол эцэг, эхийн хариуцлагыг цуцална. Зарим тохиолдолд эцэг, эхийн хоорондын харилцаа цаашид хүүхдийн эрх, ашгийн төлөө хамтрах боломжгүй хэмжээнд хүрсэн бол эцэг, эхийн хариуцлагыг цуцлах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Гурав. ИХ БРИТАНИ УЛС

Их Британид асран хамгаалагчийн хариуцлагыг эцэг, эхийн хариуцлага (**parental responsibility**) гэсэн ойлголтын хүрээнд авч үздэг. Эцэг, эхийн хариуцлагын талаарх ойлголтыг Хүүхдийн тухай /1989 оны/ хуульд²⁴ тодорхойлсон байна. Уг хариуцлага нь хүүхдийн төрсөн эцэг, эхээс гадна хуулийн дагуу эрх, үүрэг хүлээсэн бусад этгээд, байгууллагад хамаарна.

Хуульд эцэг, эхийн хариуцлагын талаар тусгахдаа эцэг, эхийн хариуцлага гэж хүүхэд, түүний өмч хөрөнгөд хамааралтай олгогдсон эрх, үүргийг ойлгоно гэж тодорхойлжээ. Их Британид насанд хүрээгүй хүүхдийг хараа хяналтгүй орхих тохиолдолд холбогдох байгууллагаас эцэг, эхэд эрүүгийн хуулийн дагуу шийтгэл ногдуулдаг байна.

Дөрөв. БНСУ

Жендерийн тэгш байдал, гэр бүлийн яамнаас 2021 онд “Хүүхдийн асран хамгаалах газарт хандсан бага насны хүүхдийн ахуйн байдал /위기청소년 지원기관 이용자 생활실태조사/” судалгааг харвал тус байгууллагаас тусламж авсан бага насны хүүхдийн 44% нь эцэг, эх, асран хамгаалагчийн хүчирхийлэл /бие мах бодийн/-д өртсөн, 46% нь хэл амаар доромжлуулсан гэсэн бол гэрээсээ гарсан шалтгааны 69.5% нь гэр бүлийн зөрчилдөөн, 44.4 % нь чөлөөтэй амьдрахыг хүссэн, 28% нь гэр бүлийн хүчирхийлэл гэж хариулжээ. Энэ нь тус улсад гэр бүлийн харилцаанд хүүхдийн хүчирхийллийн асуудал их буйг харуулж байна.

²⁵ Төрөл садан гэдэгт цусан төрлийн 8 үе доторх садан, 4 үе доторх хамаатан, хууль ёсны гэр бүлийн 4촌 이내의 인적 배우자

Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгаалалтай холбогдох зохицуулалтыг Хүүхэд хамгааллын тухай хууль, Иргэний хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд тусган гэр бүлийн харилцаанд хүүхдийг хүчирхийлсэн эцэг, эхийн эцэг, эх байх эрхийг хасах, түр түдгэлзүүлэх зохицуулалтыг тусгажээ.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлд “хотын дарга-аймгийн засаг дарга-дүүрэг-хорооны дарга-прокурор нь эцэг, эх байх эрхээ зүй бусаар ашиглах, хүүхдийг сэтгэл санаа, бие мах бодийн хувьд хүчирхийлэх гэх зэрэг хүүхдийн эрхийг хүндээр зөрчсөн тохиолдолд шүүх эцэг, эх байх эрхийг хэсэгчлэн хязгаарлах эсхүл тухайн эрхийг хасах шийдвэр гаргана.” гэж зааж хүүхдийн эрх зөрчигдөх тохиолдолд прокуророос гадна орон нутгийн засаг захиргааны байгууллага шүүхэд өргөдөл гарган шийдвэрлүүлэх үүргийг ногдуулсан байна.

Мөн Иргэний хуулийн 924 дүгээр зүйлд “Гэр бүлийн шүүх нь эцэг, эх байх эрхээ зүй бусаар ашиглан хүүхдийн эрхийг зөрчсөн, зөрчих эрсдэл байгаа тохиолдолд хүүхэд, хүүхдийн төрөл садан,²⁵ прокурор болон орон нутгийн засаг захиргааны даргын өргөдлөөр эцэг, эх байх эрхийг хасах, түр түдгэлзүүлэх шийдвэр гаргаж болно.”, “Гэр бүлийн шүүх нь эцэг, эх байх эрхийг түр түдгэлзүүлэхдээ хүүхдийн байр байдал, хүмүүжиж орчин гэх мэтийг харгалзан 2 жил хүртлэх хугацаагаар хязгаарлана.” гэж заажээ. Энэхүү Иргэний хуулийн заалт нь нэг талаас хүүхдийн эрхийг хамгаалах зохицуулалт боловч нөгөө талаас эцэг, эх байх эрхийн хязгаарлалтыг хуулиар тогтоосноор хүний эцэг, эх байх эрхийг хамгаалах цаашлаад хүүхэд эцэг, эхийн хамт өсөн бойжих эрхийг хангах зохицуулалт юм.

Эцэг, эхийн эрхийг хасах, түр түдгэлзүүлэх тохиолдолд нэн түрүүнд анхаарах зүйл бол хүүхдийг хэн асран халамжлах вэ гэдэг асуудал. БНСУ-ын хувьд хүүхдийн асран хамгаалагчийг хотын дарга-аймгийн засаг дарга-дүүрэг-хорооны дарга, хүүхэд хамгааллын байгууллагын даргын санал болгосноор түр томилж болох бөгөөд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд яаралтай эмнэлгийн тусламж үзүүлэх, асрамжын газраар хангах арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.

²⁵ Төрөл садан гэдэгт цусан төрлийн 8 үе доторх садан, 4 үе доторх хамаатан, хууль ёсны гэр бүлийн 4 чон 이내의 인적, 배우자

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээд нь эцэг, эх бол түүний эцэг, эх байх эрхийг хязгаарлаж болно.” гэснээр гэр бүлийн орчинд хүүхдийг хүчирхийлсэн эцэг, эхийн эрхийг хязгаарлах бөгөөд уг хугацааг Иргэний хуульд зааснаар 2 жил хүртлэх хугацаагаар тогтоно.

Сүүлийн үед Хүүхэд хамгааллын тухай хууль болон Гэр бүлийн маргаан хянан шийдвэрлэх тухай хууль нь эдийн засаг, нийгмийн өөрчлөлт, гэр бүлийн хэлбэр, харилцаа үүнд холбогдох маргааныг хязгаарлагдмал хүрээнд шийдвэрлэж байна гэх шүүмжлэл дагуулаад байгаа билээ. 2021 онд Хууль зүйн яамнаас тус хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг өргөн барьсан бөгөөд гол агуулга нь хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн бол эцэг, эхээсээ татгалзах эрх зүйн зохицуулалтыг шинээр оруулсан юм. Өөрөөр хэлбэл, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн эцэг, эхийн эрхийг хасах, түр түдгэлзүүлэх тухай өргөдлийг хотын дарга аймгийн засаг дарга дүүрэг хорооны дарга прокурор шүүхэд гаргадаг байсан бол гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд мөн шүүхэд өргөдөл гаргаж болох зохицуулалтыг оруулсан байна.

Гэхдээ энэхүү зохицуулалт нь хүүхдийн эрхийг хамгаалах зохицуулалт боловч дээрх эрхийг хүүхдэд эдлүүлэх нь хэт эрсдэлтэй гэх болгоомжлол нийгэмд байна.

26

Дүгнэлт, санал

Манай улсын хувьд эцэг, эх нь, эсхүл төрөл, садангийн хүн, бусад иргэн, хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын өргөдлөөр шүүх эцэг, эх байх эрхийг хасах, түр хугацаагаар хязгаарлах зохицуулалтыг Гэр бүлийн тухай хуульд тусгасан байна. Гэвч эцэг, эх байх эрхийг хасах, түр хугацаагаар хязгаарлах шалтгаан нь утгын хувьд ижил байгааг анхаарч, тодорхой байдлаар тусгах хэрэгтэй. Мөн эцэг, эх байх эрхийг “түр хугацаагаар” хязгаарлах тохиолдолд “дээд” хугацааг хуулиар тогтоох ёстой. Учир нь хүний жам ёсны эрх болох эцэг, эх байх эрхийг тодорхойгүй хугацаагаар хязгаарлах нь хүний эрхийн зөрчил болно.

²⁶ 친권제한제도, 어떻게 생각하세요 : 네이버 블로그 (Сүүлд үзсэн: 2023.6.15.)

Эцэг, эх байх эрхийг хасах, түр хязгаарлах тухай өргөдлийг эцэг, эх нь, эсхүл төрөл, садангийн хүн, бусад иргэн, хүүхдийн эрхийг хамгаалах байгууллага шүүхэд гаргаж буй явдал нь эрх нь зөрчигдөж буй хүүхдийн үүднээс хязгаарладмал байдал үүсгэх талтай учир тодорхой нас /13 наснаас дээш/-аас дээш хүүхэд өөрөө шүүхэд өргөдөл гарган асран хамгаалагч болох эцэг, эхийн эрхийг хасуулах, түр хязгаарлуулах боломжоор хангах нь “эцэг, эх төв”-тэй гэр бүлийн хэлбэрээс “хүүхэд төв”-тэй гэр бүлийн хэлбэрийг бий болгох нэгэн оролдлого болох бөгөөд энэ нь хүүхэд хамгааллын тал дээр чухал ахиц гаргана хэмээн үзэж байна.

Эцэст нь эцэг, эх байх эрхийг хасаад, хүүхдийг асран хамгаалах төвд шилжүүлэн гарсан зардлыг эцэг, эхээс эргүүлэн гаргуулах зохицуулалтай ч төлбөрийн чадваргүй бол яах ч аргагүй байдалд ордог. Тиймээс улс хүүхэд хамгааллын санг бий болгох, эрхээ хасуулсан эцэг, эхийг албадан хөдөлмөрлүүлэх талаар хуульд тусгах нь зүйтэй.

Мөн судлагдсан гадны улсын жишгээр хүүхдийн хүчирхийлэл гэдгийг хүүхдийг сэтгэл зүйн дарамтад оруулах, бие мах бодид хүчирхийлэл үзүүлэхээс гадна хүүхдийн эд хөрөнгийг хамгаалах ойлголтыг оруулж хүүхдийн хөрөнгийг дур мэдэн захиран зарцуулахаас урьдчилан хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

3.3. Хүн амын удмын сангийн аюулгүй байдал ба гэрлэх нөхцөл

2023 оны байдлаар Монгол Улсын нийт хүн амын тоо 3.457.548 байгаа²⁷ бөгөөд энэхүү тоон үзүүлэлт нь дэлхийн 195 улсаас 135-д эрэмбэлэгдэж байна. Хүн амын тоо бага байх хэрээр цус ойртолтын магадлал өндөр байдаг. Цус ойртолт гэдэг нь ураг төрлийн холбоо бүхий этгээдүүд хоорондоо ураг болж гэр бүл болсны дүнд бий болох бөгөөд удмын 3-4 дэх үеийн ах дүү нар гэрлэхэд цус ойртолт $FIT=0.0651$ бий болдог байна.

Манай улсын хувьд нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын суурьшлаас хамааран ураг төрөл хоорондоо гэр бүл болж цус ойртох тохиолдол цөөнгүй байна. Үүний гол шалтгаан нь хөдөө орон нутгаас хот суурин газрыг чиглэсэн хүн амын

шилжилт хөдөлгөөн ихэсч орон нутгийн иргэдийн тоо багассантай холбоотой. Цус ойртолт нь дараах сөрөг үр дагаврыг үүсгэнэ. Үүнд:

- Өвчний олон улсын Х ангиллын 19 бүлэг өвчин, 32 төрлийн хорт хавдраар өвчлөл ихсэх,
- “Оюуны хомсдол”-ын тохиолдол нэмэгдэх,
- Төрөлхийн хөгжлийн бэрхшээл, гажигтай хүүхдийн тоо нэмэгдэх гэх мэт үр дагавар илэрч байна.²⁸

1990 онд ЕБС-ийн 1.547 хүүхдийг хамруулж хийсэн судалгаанд нийт хүүхдийн 1,3% буюу 1000 хүүхэд тутмын 13.2% нь оюуны хомсдолтой гэж оношлогдож тэдний 41.7% нь удмын шалтгаантай гэсэн дүгнэлт гарчээ.²⁹

Дэлхийд оюуны хомсдолын шинжийг дүгнэхдээ 1000 хүнд 10 байхад хэвийн гэж үздэг бол Монголд оюуны хомсдолын шинж :

- 1986 онд 1000 хүн тутмын 8.4 хүн,
- 1997 онд 1000 хүн тутамд 11-12 хүн,

Одоо 1000 хүн тутамд 13 байгаа бөгөөд 10 жилд 3.1 хүнээр нэмэгдэж байна.³⁰

Энэхүү асуудлыг шийдвэрлэх үүднээс УИХ-аас 1996 онд “Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлого”, 2006 онд “Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”, 2003 онд “Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого”, 2010 онд “МУ-ын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, 2020 онд “МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, 2022 онд “Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, хүн амын өсөлтийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай” зэрэг бодлогын болон эрх зүйн баримт бичгийг батлан хэрэгжүүлж байна. Гэсэн хэдий ч энэхүү баримт бичгүүд нь хүний удмын санг хамгаалах эрх зүйн орчныг бүрэн бүрдүүлж чадахгүй байна.

“АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавхыг

бэхжүүлж, монгол хүний хөгжлийг дэмжих зорилгоор цөөнгүй арга хэмжээг хэрэгжүүлж буй боловч тодорхой үр дүнд хүрэхгүй байгааг онцлох нь зүйтэй.

Цус ойртолт нь хүн амын шилжилт хөдөлгөөнтэй нягт холбоотой тул үүнийг хөдөө орон нутаг, хот суурин газрын тэнцвэртэй хөгжлийг хангаж орон нутаг дахь иргэдийн тоог нэмэгдүүлэх бодлого баримтлах нь бодитой үр дүнд хүрэх боломжтой. Өөрөөр хэлбэл, батлан хэрэгжүүлж байгаа бодлогын баримт бичигт хөдөө орон нутгийн хөгжлийг дэмжсэн бодитой арга хэмжээг тусган хэрэгжүүлэх хэрэгтэй. Мөн Гэр бүлийн тухай хуульд гэрлэхэд харшлах шалтгааныг заасан боловч нийтлэг байдлаар буюу “төрөл садан” гэх байдлаар тусгасныг нарийвчлан тусгах шаардлагатайгаас гадна энэхүү үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих төрийн институт байгуулах тал дээр анхаарах нь зүйтэй юм.³¹ Түүнчлэн ураг төрөл хоорондоо “гэр бүл” болж буй явдал нь удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалахад голлох нөлөө үзүүлж буйг анхаарч иргэдийн боловсролыг дээшлүүлэх чиглэлд анхаарах нь зүйтэй.

Гадаад улсын хүн амын аюулгүй байдал ба удмын сангийн бодлого, түүнийг хамгаалах, зохицуулалт

Олон улсын түвшинд хүний удмын сантай холбоотой дараах олон улсын гэрээ тунхаглал байна. Үүнд: НҮБ-ын 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал,³² Генетикийн нөөц болон тэдгээрийг ашигласанаас үүдэх үр ашгийг шударга, эрх тэгш хуваарилах тухай Нагоягийн протокол, НҮБ-ын 1997 оны Хүний геном ба хүний эрхийн түгээмэл тунхаглал³³ зэрэг олон улсын гэрээ, тунхаг бичгүүд байна.

Нэг. БНХАУ

Хүн амын удмын санг бүхлээр нь зохицуулдаг хуультай улс бол зөвхөн БНХАУ юм. Тус улсын Хүний генетикийн нөөцийн менежментийн тухай хууль /Regulation on the Management of Human Genetic Resources/ нь 2019 онд батлагдсан ба нийт 6 бүлэг 47 зүйл заалттай.³⁴ Тус хууль нь хүний генетик нөөцийг

зөв зохистой хамгаалах, ашиглах, нийгмийн эрүүл мэнд, үндэсний аюулгүй байдал, нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой.

Хоёр. Бусад улс орнууд

Исланд улс удмын сангийн бүртгэлжүүлэлтийг 1703 онд эхэлсэн бөгөөд өнөөг хүртэл удмын хэлхээг тодорхой байдлаар хадгалсаар ирсэн. Солонгос улсын хувьд 2007 оноос Америкийн Нэгдсэн Улсын Юта мужийн “Family search” байгууллагатай хамтран мянга гаруй овгийн угийн бичгийг тоон системд шилжүүлсэн бол Шотланд улс 2007 оноос 50 сая гаруй удмын мэдээллийг цахим хэлбэрээр хадгалдаг болсон байна.³⁵

Бусад улс орны хувьд Удмын сангийн аюулгүй байдлын талаарх харилцааг Эрүүгийн хуулиар зохицуулсан 23 улс, Иргэний хуулиар зохицуулсан 7, Гэр бүлийн хуулиар зохицуулсан 9, бие даасан хуулиар зохицуулсан 4 улс байна.³⁶

Судалгаанд хамруулсан улс орны хуулийн зохицуулалтаас харахад цус ойртсон гэрлэлтийг хууль бус гэрлэлт гэж үзэх бөгөөд гэрлэх нөхцөлд өөрийн улс оронд нийцэхүйц хязгаарлалтыг тавьдаг байна.

Дүгнэлт, санал

ГБТХ-ийн 9 дүгээр зүйлд гэрлэхэд харшлах шалтгааныг зүйлчилсэн. Мөн тус хуулийн 7.1-т гэрлэх журмын талаар тусгахдаа гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ гэрчийн этгээдийг байлцуулан улсын бүртгэлийн байгууллага, Дипломат төлөөлөгчийн газарт гэрлэлтээ бүртгүүлэхээр хуульчилсан байна. Гэрлэлт бүртгэх явц дахь тухайн төрийн байгууллага хяналт хийх чиг үүргийг бий болгох шаардлагатай. Мөн угийн бичиг хөтлөлтийг цахимжуулснаар цаашид хүн амын эрүүл мэнд, удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах хууль, эрх зүйн орчинг хамгаалах таатай орчин бий болох юм.

Мөн бусад орны туршлагад үндэслэн дүгнэхэд цус ойртсон гэрлэлтийг Эрүүгийн тухай хуульд гэмт хэрэг гэж үзэж хариуцлага тооцдог бол Монгол улсын хувьд Эрүүгийн хуульд цус ойртох гэх агуулгатай гэмт хэрэг байхгүй байна.

Эрүүгийн хууль нь зөвхөн гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх боловч мөн урьдчилан сэргийлэх ач холбогдолтой байдаг. Тухайлбал, нийгэмд тухайн зүйлийг үйлдэх нь буруу, гэмт хэрэг гэх ойлголтыг өгөх боломжтой бөгөөд ГБТХ болон Эрүүгийн хуулийн уялдаа холбоог ханган хуульчилбал зохино.

3.4. Гэрлэлтийн гэрээ

Гэрлэлтийн гэрээ нь гэрлэгч тус бүрээс өрхийн төсөв, зардлыг хариуцах журам, гэрлэлтийг цуцалсан нөхцөлд ногдох эд хөрөнгийг тодорхойлох, эд хөрөнгийн эрхтэй холбогдсон бусад нөхцөлийг Иргэний хуульд нийцүүлэн байгуулсан иргэний эрх зүйн гэрээг ойлгоно.³⁷

Тус гэрээг Иргэний хуульд дараах байдлаар зохицуулжээ. Үүнд :

Зүйл заалт	Агуулга
125.2	Гэрлэгчдийн хөрөнгийн эрхийн зарим харилцааг гэрээгээр зохицуулж болно.
132.1	Гэрлэгчид гэрлэгч тус бүрээс өрхийн төсөв, зардлыг хариуцах журам, гэрлэлтийг цуцалсан нөхцөлд ногдох хөрөнгийг тодорхойлох, хөрөнгийн эрхтэй холбогдсон бусад нөхцөлийг энэ хуульд нийцүүлэн байгуулсан гэрээний үндсэн дээр зохицуулж болно.

Гэрлэлтийн гэрээнд дараах нөхцөлийг тусгаж болно. Үүнд:

- Хамтран болон хэсгээр өмчлөх дундын хөрөнгө, хөрөнгийн эрх, үүргийн хуваарилалт,
- Тусдаа амьдрах, хэн нэг нь нас барахад хөрөнгө хуваах журам,
- Тэжээн тэтгэх, халамжлах үүрэг
- Хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, хүмүүжил, асрамжийн эрх, үүрэг зэрэг багтана.

Гэрлэлтийн гэрээ нь гэр бүл цуцлах тохиолдолд эд хөрөнгийн маргааныг шийдвэрлэхэд голчлон хэрэглэгдэнэ. Сүүлийн 5 жил (2017-2021 он)-ийн хугацаанд Гэр бүлийн хуулийн дагуу хянан шийдвэрлэсэн хэргээс 60.4 хувь буюу 14021 гэрлэлт цуцлах маргааныг хянан шийдвэрлэжээ.

Үүнээс 2017 онд гэрлэлт цуцлуулах нийт 2791 хэрэг шийдвэрлэсэн бол 2018 онд үүнээс 154 хэргээр олон буюу буюу 5.5% хувиар өссөн байна. 2019 онд гэрлэлт цуцлуулах хэргийн тоо өмнөх оноос 209 хэрэг буюу 7%-иар буурсан ч 2021 онд 2020 онтой харьцуулахад 97 хэргээр олон буюу 3.5%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Статистик тоон үзүүлэлтийг харвал хойшдоо гэрлэлт цуцлалт өсөх магадлалтай байгааг анхаарч үүнээс үүдэлтэй гэрлэгчдийн харилцаан дахь эд хөрөнгийн болон хөрөнгийн бус, хүүхэд асран хамгаалах, харилцан биесээ асрах, тэтгэхэд холбогдох харилцааг гэрээгээр тохирох ойлголтыг суулгаж, тухайн харилцаанд холбогдох маргааныг гэрээгээр шийдвэрлэх бодит хэрэгцээ үүсээд байна.

Мөн Иргэний хуульд заасан гэрлэлтийн гэрээнд хүүхэд асран хамгаалах, тэжээн тэтгэхэд холбогдох эрх, үүргийн талаар нарийвчлан тусгаагүй ч Гэр бүлийн тухай хуулийн 21.5-д зааснаар “...гэрлэлтээ бүртгүүлээгүй хүмүүсийн дундаас төрсөн хүүхэд болон гэрлэгчдийн хэн нэгний нь дагавар хүүхэд нь гэрлэлтээ бүртгүүлсэн болон гэрлэгчдийн дундаас төрсөн хүүхдийн адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ.” гэж заасан. Гэрлэлтийн гэрээнд холбогдох энэхүү хоёр хуулийн зүйл заалтыг илүү нарийвчлан эдийн бус харилцааг тодорхойлох, хүүхэд асран хамгаалах эрх, үүргийг тодорхой тусгах нь зүйтэй.

Гадаад улсын гэрлэлтийн гэрээ болон гэрлэгчийн хөрөнгийн эрхтэй холбоотой гэрээний эрх зүйн зохицуулалт

Нэг. ОХУ

ОХУ-ын Гэр бүлийн тухай хуулийн 8 дугаар бүлэгт гэр бүлийн гишүүдийн хөрөнгийн харилцаатай холбогдох гэрээний талаар зохицуулжээ. Тус гэрлэлтийн гэрээнд эхнэр, нөхрийн хуваарьт хөрөнгийн хэмжээг тогтоох (хуулийн 34-р зүйл), дундын хөрөнгө, тэдгээрийн төрөл, зүйлүүдийг тусгаж болно. Мөн хөрөнгийн харилцаанаас гадна эхнэр, нөхрийн эрх, үүргийг тодорхойлох, харилцан тэтгэх, гэр бүлийн орлого бүрдүүлэх хэлбэр, зарлага хариуцах хэмжээ, гэрлэлт цуцалсан тохиолдолд шилжүүлэх эд хөрөнгийн жагсаалт гэх мэт бусад зүйлс багтана.

Харин тус хуулийн 42.3 дахь хэсэгт гэрлэлтийн гэрээнд гэрлэгчдийн эрх зүйн чадамжийг хязгаарласан, аль нэг гэрлэгчийн эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандах эрхийг хязгаарласан, гэрлэгчид хоорондын хөрөнгийн бус харилцааг зохицуулсан, хүүхэдтэй холбогдох эцэг, эхийн үүргийн талаар зохицуулсан нөхцөлүүдийг тусгахыг хориглодог ба 41.2 дахь хэсэгт гэрлэгчийн гэрээг бичгээр байгуулж, нотариатаар баталгаажуулахыг шаарддаг байна. Дээрх бүгдээс харахад ОХУ-д гэрлэлтийн гэрээнд тавигдах шаардлага, хориглох зүйлс гэх зэрэг зохицуулалт нь манай улсын гэрлэлтийн гэрээнд тавигдах хууль зүйн шаардлагатай төстэй байна.

Хоёр. ХБНГУ

ХБНГУ-д Гэр бүлийн тухай хууль нь Иргэний хуулийн нэг хэсэг байдаг ба тус хуулийн 1408 дахь зүйлд гэрлэлтийн гэрээг хуульчилж өгсөн байна. Тодруулбал, “гэрлэгчид гэр бүлийн хөрөнгийн харилцааг гэрээгээр зохицуулж болно.”, 1408.2 дахь зүйлд талууд гэрээнд тэтгэвэртэй холбоотой заалтыг тусгаж болдог ба энэ тохиолдолд талуудад Тэтгэвэр тэтгэмж тэнцэтгэх тухай хуулийн 6-8 дугаар зүйл үйлчлэхээр хуульд тусгасан байна. Мөн 1410-р зүйлд Гэрлэлтийн гэрээг нотариатаар баталгаажуулахад хоёр тал нь заавал байх ёстой.

Хуулиар гэрлэлтийн гэрээг байгуулахад гэрлэгчийн эрх, үүрэг чадамжийг тодорхойлох нь ач холбогдолтой ч иргэний эрх зүйн чадамжгүй этгээдийн бусадтай гэрлэх боломжийг хуулиар хязгаарласан байдаг ч гэрлэлтээ бүртгүүлчихсэн иргэдийн хувьд гэрлэлтийн гэрээг байгуулахад зайлшгүй эрх зүйн чадамжтай байхыг шаарддаггүй байна.

Иргэний хуулийн 1411 дэх зүйлд эрх зүйн чадамж нь хязгаарлагдмал этгээдийн гэрлэлтийн гэрээний талаар тусгасан байх ба ингэхдээ гэрлэлтийн гэрээг хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөлтэйгөөр байгуулах ёстой байдаг. Үүнд: гэрлэгчийн асран хамгаалагч бол гэрлэлтийн гэрээг байгуулахад хууль ёсны төлөөлөгчөөс гадна гэр бүлийн шүүхийн зөвшөөрлийг авсан байх шаардлагатай. Мөн гэрлэгчийн харгалзан дэмжигч байх тохиолдолд гэрлэлтийн гэрээг байгуулахад хууль ёсны төлөөлөгчөөс гадна шүүхээс зөвшөөрөл авах шаардлагатай байдаг байна.

Дүгнэлт, санал

Харьцуулан судалсан улс оронд гэр бүлийн дундын эд хөрөнгийн зохицуулалтыг манай улстай адил Иргэний хууль, Гэр бүлийн тухай хуулиар зохицуулж байна.

Манай улсын хувьд гэрлэлтийн гэрээ буюу гэрлэгчдийн хөрөнгийн эрхтэй холбогдсон гэрээгээр гэрлэгчдийн хөрөнгийн дэглэмийг харилцан тохиролцон тогтоох боломжийг олгосон байх ба гэр бүл болохоос өмнөх хөрөнгө болон гэр бүл болсноос хойш үүссэн дундын хөрөнгийг захиран зарцуулах эрх, түүний хуваарилалт, өр төлбөрийг ямар хөрөнгөөр зохицуулах зэргийг тусгаснаар гэрлэлт цуцлах тохиолдолд ямар нэгэн байдлаар эдийн болон эдийн бус харилцаатай холбогдсон маргаан гарахаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Мөн гэрлэлтийн гэрээгээр зөвхөн эд хөрөнгийн харилцаа бус, харилцан тэжээн тэтгэх үүрэг, хүүхэд асран хүмүүжүүлэх талаар харилцан эрх тэгш байдлыг зохицуулдаг нь гэр бүл болсноор үүсэх маргаан, зөрчлөөс сэргийлэх боломжтой байдгаараа давуу талтай юм.

3.5. Донор ба тээгч эхийн эрх, үүрэг /Нөхөн үржихүйн туслах аргыг ашигласны үр дүнд төрсөн хүүхдийн эцэг, эхийг тогтоох/

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн чухал хэсэг нь үргүйдэл бөгөөд 2010 оны байдлаар дэлхий даяар 48.5 сая хос, хөгжиж буй орнуудад дөрвөн хос тутмын нэг нь үргүйдэлтэй болох нь тогтоогдсон бөгөөд энэ хэрээр тээгч эхээр үр тээлгэж төрүүлэх явдал харьцангуй нэмэгдэж байна. Энэ нь нэг талаас үр удмаа үлдээх гэсэн хүний жам ёсны харилцаа боловч нөгөө талаас үр тээсний төлөө тодорхой төлбөр авдаг бизнесийн харилцаа юм.

Тээгч эхээр хүүхэд тээлгэх гол шалтгаан нь нөхөн үржихүйн үйл явцыг хялбаршуулах технологиин хөгжил болон хувь хүний “үргүйдэл”-ээс хамааралтай хэмээн тайлбарлаж байна.

Үргүйдлийн үр дагавар зөвхөн гэр бүлийн асуудлаар хязгаарлагдахгүй. Тухайлбал, улс хүн амын өсөлт, нийгмийн хэв шинжид нөлөөлөх бөгөөд хувь

хүний хувьд стресс, сэтгэл гутрал зэрэг сэтгэл зүйн өөрчлөлт үүсгэн улмаар гэр бүлийн хүчирхийлэл, салалт асуудлын шалтгаан болдог.³⁸

Манай улсын хувьд үргүйдлийн талаар хийгдсэн судалгааны ажил ихэнхдээ эмнэлэгт суурилсан эмнэл зүйн судалгааны загвараар хийгдсэн бөгөөд хүн амд суурилсан үргүйдлийн тархалт, шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлсон судалгаа хомс байна. Үргүйдэлд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлүүдийн талаар хийсэн судалгаанаас харахад 2013 оны байдлаар үр хөндөлтийн 15628 тохиолдол бүртгэгдэж, нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйн 18.4% нь үр хөндөлт хийсэн тохиолдол байгаа бол бэлгийн замаар дамжих халдварын 14904 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 39.9 хувийг эзэлж, өнгөрсөн онтой харьцуулахад 10000 хүн амд 1.5-аар нэмэгдсэн байна.

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн “Монгол хүний үргүйдлийн шалтгаан” судалгааны дүнгээс үзэхэд нийт үргүйдэлтэй хосын дунд эмэгтэйчүүдийн 34,8 хувь, эрэгтэйчүүдийн 55,6 хувь нь ямар нэг эмгэг өөрчлөлт илрээгүй буюу шалтгаан тодорхойгүй үргүйдэлтэй, эмэгтэйчүүдийн 56,3 хувь нь анхдагч, 43,7 хувь нь хоёрдогч үргүйдэлтэй байна. Бэлгийн замаар дамжих халдварт өртсөн байдлыг харахад эрэгтэйчүүдийн 44,1 хувь нь, эмэгтэйчүүдийн 43,9 хувь нь уг халдварт өртөж, үүнээс 25,1 хувь нь бага аарцгийн үрэвсэлт өвчнөөр, эмэгтэйчүүдийн 23 хувь, эрэгтэйчүүдийн 53 хувь нь бэлгийн дааврын үзүүлэлтийн хувьд ямар нэг өөрчлөлт буюу дотоод шүүрлийн тогтолцоонд эмгэгтэй байна.

Үндэсний статистикийн хорооны албан мэдээлэл судалгаанаас харахад судалгаанд хамрагдсан гэрлэсэн буюу хамтран амьдрагчтай байгаа 15-49 насны 8674 эмэгтэйчүүдийн 5,1 хувь нь үргүйдэлтэй буюу сүүлийн 5 жилд хүүхэд төрүүлээгүй, жирэмснээс хамгаалах арга огт хэрэглэдэггүй, хүүхэдтэй болохоор төлөвлөсөн ч жирэмслэхгүй байгаа, 6,8 хувь нь цэвэршсэн, саваа авхуулсан гэж, 11,9 хувь нь үргүйдэлтэй гэдгээ хүлээн зөвшөөрч түүвэр судалгаанд оролцжээ.

2016 оны байдлаар үргүйдлийн асуудлаар 1909 иргэн бүртгүүлэн үзүүлж, эмчилгээ үйлчилгээ авчээ. Үргүйдлийн асуудалтай, үр шилжүүлэн суулгах аргаар

үр хүүхэдтэй болох хүсэлтэй иргэд БНСУ болон ОХУ-ын эмнэлэгт их ханддаг бөгөөд 2015 онд БНСУ-д зорчихоор эмчилгээний виз авсан 3700, 2016 онд 3100, 2017 онд 3800, 2018 оны эхний хагас жилийн байдлаар 1900 хүн байгаа нь гадагш эмчилгээ, үйлчилгээнд явах хүсэлтэй, түүнээс нөхөн үржихүйд туслах аргаар үр хүүхэдтэй болох хүсэлт их байгааг харуулж байна.

Олон улсын нөхөн үржихүйд туслах аргын хувьд үргүйдлийн оношилгоо, эмчилгээнд хамруулахад зөвхөн донор бэлгийн эс хэрэглэх шаардлагатай байдаг. Мөн тодорхой өвчний улмаас умай тайруулсан, авахуулсан, умайн төрөлхийн гаж хөгжилтэй эмэгтэйчүүд зөвхөн тээгч эхийн тусламжтай хүүхэдтэй болох боломжтой байдаг байна.

Дээрхээс дүгнэхэд, манай улсад үр шилжүүлэн суулгах, тээгч эхийн тусламжтайгаар хүүхэд төрүүлэх хэрэгцээ, шаардлага нэгэнт үүссэн бөгөөд энэхүү харилцааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлага тулгараад байна. Тодруулбал, Монгол Улсад 2011 оны 11 дүгээр сард анхны үр шилжүүлэн суулгах төв байгуулагдаж байсан бол 2018 оны байдлаар Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, “Си эйл даблью эйч”, “Өөжин мед”, “Баянгол” зэрэг эмнэлэгт үр шилжүүлэн суулгах эмчилгээ, үйлчилгээг явуулж байгаа бөгөөд нэг эмнэлэгт жилд 300-500 хос хандаж, оношилгоо, эмчилгээ үйлчилгээ авч байна.³⁹

2021 оны байдлаар үргүйдлийн нөхцөл байдал дээрдээгүй байх бөгөөд Монгол Улсын нийт гэр бүлийн 10 хувь нь үргүйдлийн асуудалтай⁴⁰ бөгөөд дунджаар 7-8 хос тутмын 1 нь үргүйдлийн асуудалтай тулгарч байна.⁴¹ Цаашид хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэнд, үр тогтох чадвар сулрах магадлалтай байна.⁴²

Донор болон тээгч эхийн талаар Монгол Улсын хууль тогтоомжид дараах байдлаар зохицуулж байна. Үүнд:

Донорын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15-д донор бэлгийн эсийг тодорхойлохдоо **өөр хүний эр, эм бэлгийн эс** хэмээж, тус зүйлийн 3.1.16-д тээгч эхийг **бусдын үр хөвөрлийг тээж, хүүхэд төрүүлэх эмэгтэй** гэж тусгажээ.

Мөн хуулийн 18 дугаар зүйлийн 5-д “Эрүүл мэндийн шалтгаанаар өөрөө жирэмслэх, ураг тээх, хүүхэд төрүүлэх чадваргүй нь эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон эмэгтэйг тээгч эхээр дамжуулан хүүхэдтэй болохыг зөвшөөрнө.”, 7-д “Донор бэлгийн эс ашиглах, үр хөврөлийг шилжүүлэн суулгах, тээгч эхэд үзүүлэх тусламж, үйлчилгээний журам, талуудын хооронд байгуулах гэрээний загварыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж тусгасан байна.

Үүний дагуу Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/500 дугаар тушаалаар Донор бэлгийн эс ашиглах, үр хөврөл шилжүүлэн суулгах журам, Тээгч эхэд үзүүлэх тусламж, үйлчилгээний журам, Үр шилжүүлэн суулгах эмчилгээнд тээгч ашиглах талуудын хооронд байгуулах гэрээний загварыг тус тус баталсан.

Донор бэлгийн эс ашиглах, үр хөврөлийг шилжүүлэн суулгах тухай журмын 4.3.6-д эмчилгээний үр дүнд төрсөн хүүхдийн өмнө ямар нэг хуулийн болон санхүүгийн үүрэг хариуцлага хүлээхгүй, хүүхдийг өөрийн төрсөн хүүхэд гэж нэхэмжлэхгүй гэж тусган бэлгийн эсийн донорын үүргийг тогтоожээ. Дээр дурьдсанчлан тээгч эх нь тодорхой төлбөр авч хүүхэд тээж байгаа бизнесийн харилцаа боловч тээгч эх хүүхэд тээж, төрүүлсний дараа тухай хүүхдийг өгөхгүй байх тохиолдол болон өөрийн төрсөн хүүхэд хэмээн нэхэмжлэх эрхийг журмаар зохицуулж байгаа нь хүний эрхийн зөрчил үүсгэж болзошгүй байгааг анхаарах хэрэгтэй.

Нөхөн үржихүйн дэмжигч буюу тээгч эх нь хүүхэдтэй болж чадахгүй байгаа хүнд өөрийн үр удмаа үлдээх боломжийг олгох, гэр бүлийн харилцааг тогтворжуулах сайн талтай ч тээгч эх гэх нэрийн доорх хүний наймаа ихсэх, тээгч эх хүүхэд төрүүлсний дараа хүүхдийг өгөхгүй байх гэх мэт эрсдэлтэй бөгөөд нөгөө талаас хүүхэд ямар нэгэн хэмжээгээр гажигтай төрөх тохиолдолд түүнээс татгалзах гэх мэт сул талтайг анхаарч дотоодын эрх зүйг сайжруулах хэрэгтэй.

Хүснэгт 3.Нөхөн үржихүйн техник технологи буюу тээгч эхийн давуу, сул тал

Давуу тал	Сул тал
1. Хүүхэдтэй болж чадахгүй байгаа хосууд	1. Тээгч эх ашиглаж хүүхэдтэй болох

<p>өөрийн үр удамтай болох боломжтой,</p> <p>2. Хүүхэдгүй ихэнх эмэгтэйчүүд сэтгэл зүйн хувьд тогтворгүй болдог тул хүүхэдтэй болсноор сэтгэл санаа нь тогтвортой болох боломжтой,</p> <p>3. Эдийн засгийн гачигдалтай хүмүүс энэ ажлыг хийнгээ мөнгөтэй болж бусдад туслах боломжтой.</p>	<p>процедур нь өндөр зардал гардаг тул мөнгөтэй хүн хийлгэх боломжтой,</p> <p>2. Тээгч эхийг ашиглан хүний наймаа ихсэх</p> <p>3. Тээгч эхийн сэтгэл санааны байдлаас болж тээсэн хүүхдийг эцэг эхэд нь өгөхгүй гэх магадлалтай</p> <p>4. Тээлгүүлэгч хүүхдийн хүйс эсвэл ургийн гажигтай гэдгийг мэдвэл хүүхдээсээ татгалзах асуудал гарах боломжтой</p> <p>5. Тээлгүүлэгчид тээгч эхийн эрүүл мэндээс илүү хүүхдийн эрүүл мэндийг илүүд үздэг.</p>
--	--

Донор ба тээгч эхийн эрх үүрэг /Нөхөн үржихүйн туслах аргыг ашигласны үр дүнд төрсөн хүүхдийн эцэг, эхийг тогтоох/-тэй холбоотой гадаад орнуудын эрх зүйн зохицуулалт

Нэг. ОХУ

Гэр бүлийн тухай хуулийн⁴³ 51.4-д гэрлэгчид нөхөн үржихүйн туслах технологи ашиглаж хүүхэдтэй болсон бол тухайн хүүхдийн эцэг, эхээр нь тогтоох бол тээгч эхийн тусламжтайгаар хүүхэдтэй болсон бол тухайн тээгч эхийн зөвшөөрлөөр гэрлэгчдийг хүүхдийн эцэг, эхээр тогтооно.

Кембрижийн Их сургуулиас тээгч эхээр хүүхэд тээлгэж төрүүлэх харилцааг хүлээн зөвшөөрдөг болон зөвшөөрдөггүй орнуудын судалгааг⁴⁴ /Хүснэгт 4/ гаргасан бөгөөд судалгаанаас үзэхэд ихэнх улс орон ашгийн бус хүмүүнлэгийн зорилгоор тээгч эх болох, тээгч эхээр хүүхэд тээлгэж төрүүлэх явдлыг хүлээн зөвшөөрч байгаа бол Хятад, Герман, Итали, Япон, Франц, Турк, БНСУ зэрэг орнууд аль ч тохиолдолд хүлээн зөвшөөрдөггүй байна.

Хүснэгт 4. Тээгч эхийг хууль ёсны, хууль бус, мөн хүмүүнлэгийн зорилгоор зүйлчилсэн улс

	Хууль ёсны	Хууль бус
Нэр нь үл мэдэгдэх ДНК хандивлагчийг зөвшөөрөх	- АНУ - Англи /Хүүхэд 18 нас хүрсэн тохиолдолд хандаж болно. /	- ХБНГУ - Франц
Нэр нь үл мэдэгдэх болон	- АНУ	- Фрац

танигдсан ДНК хандивлагчийг хэрэглэх		- Швед - Япон
Хүмүүнлэгийн зорилгоор тээгч болох	- АНУ (Муж бүр ялгаатай байдлаар зохицуулж байна.) - Англи - Канад - Австрали (Муж бүр ялгаатай байдлаар зохицуулж байна.) - Дани - Грек - Энэтхэг - Мексик (Муж бүр ялгаатай байдлаар зохицуулж байна.) - Норвеги - Испани - Швед - Швецарь - Украин	- Хятад - ХБНГУ - Итали - Япон

Эх сурвалж: ШЕЗ, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны дүн мэдээ⁴⁵

Дүгнэлт, санал

Одоо хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Гэр бүлийн тухай хуульд Донорын тухай хууль /шинэчилсэн найруулга/, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/500 дугаар тушаалаар батлагдсан Донор бэлгийн эс ашиглах, үр хөврөл шилжүүлэн суулгах журмыг уялдуулах шаардлагатай. Тээгч эхээр дамжуулан хүүхэдтэй болсон тохиолдолд тухайн хүүхдээс ямар ч тохиолдолд татгалзах боломжгүй бөгөөд хүүхэд гэр бүлийн хууль ёсны гишүүн байх баталгааг хуульд нарийн тусгах нь зүйтэй. Мөн нөхөн үржихүйн туслах аргыг ашиглах гэрээ байгуулсан үр хөврөлийн донор, эсхүл тээгч эх өөрийгөө хууль ёсны эхээр тогтоолгох нэхэмжлэл гаргах эрхгүй байдлаар журамласныг Гэр бүлийн тухай хуульд нийцүүлэх хэрэгцээ байна.

3.6. Хамтран амьдрагч

Хамтран амьдрах нь сэтгэлзүйн болон эдийн засаг, бие физиологийн хэрэгцээг хангах гэрлэлтийн бүртгэл хийхгүй хамт амьдрах харилцааг ойлгоно. Гэхдээ энэхүү харилцаа нь гэр бүлийн гишүүдийн зарим үүргийг гүйцэтгэдгээрээ гэр бүлийн төлөв байдалтай төстэй ч эрх зүйн хувьд бүрэн чадамжгүй. Учир нь

“Гэр бүлийн тухай” хуульд хамтран амьдрах хэлбэр, түүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг хараахан тусгаагүй. Харин “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийн 3 дугаар зүйлд “энэ хуулийн зохицуулалтад гэрлэлтээ хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй боловч хамтын амьдралтай байгаа хүмүүс... нэгэн адил хамаарна.” гэж заасан нь хамтран амьдрагчдын талаарх цорын ганц зохицуулалт юм.

2002-2007 онд эцэг, эх нь гэрлэлтээ төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй хамтран амьдарч нарын дундаас 22.924 хүүхэд төрсөн байна.⁴⁶ Энэ нь хамтран амьдрах хугацаанд хүсээгүй жирэмслэх магадлал өндөр байж болохыг харуулж байгаа бөгөөд хүсээгүй жирэмслэлтээс үүдэн хүүхэд өнчрөх, цаашлаад нэгэнт төрсөн хүүхдэд тэтгэмж төлөхөөс зайлсхийх, хамтран амьдрах хугацаанд дундаас нь бүтсэн эд хөрөнгийн маргаан зэрэг асуудал гардаг.

Монгол улсын хэмжээнд 2020 оны байдлаар нийт гэрлэлтээ батлуулсан гэр бүл 1.110.170 байгаа бол хамтран амьдрагчид 193.581 байгаа нь хамтран амьдрагчид гэрлэлтээ бүртгүүлсэн гэр бүлийн 17%-д хүрсэнийг харуулах үзүүлэлт юм. Түүнчлэн насны бүлгээр авч үзвэл нийслэл хотод 30-34, 35-39 насны хамтран амьдрагч хамгийн их байдаг бол хөдөө орон, нутагт 35-39, 40-44 насны хамтран амьдрагч дийлэнх хувийг эзэлж байна.

Хүснэгт 5. 2020 оны байдлаар 15-аас дээш насны хүн амын гэрлэлтийн үзүүлэлт

Насны бүлэг	Хот				Хөдөө			
	Батлуулсан гэр бүлтэй		Батлуулсан гэр бүлгүй		Батлуулсан гэр бүлтэй		Батлуулсан гэр бүлгүй	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Бүгд	726950	100.0	154679	100.0	383220	100.0	38902	100.0
15-19	206	0.0	657	0.4	258	0.1	386	1.0
20-24	8921	1.2	11560	7.5	10403	2.7	4948	12.7
25-29	55327	7.6	33654	21.8	35461	9.3	9444	24.3
30-34	118094	16.2	35150	22.7	53396	13.9	6910	17.8
35-39	114270	15.7	20959	13.5	57626	15.0	4591	11.8
40-44	102948	14.2	16618	10.7	57253	14.9	3763	9.7
45-49	89881	12.4	14144	9.1	51203	13.4	3150	8.1
50-54	75972	10.5	10101	6.5	41570	10.8	2593	6.7
55-59	66842	9.2	6528	4.2	33190	8.7	1704	4.4
60+	94489	13.0	5398	3.4	42860	11.2	1413	3.6

Иймд иргэдийн гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн талаарх үүрэг, хариуцлага, хууль эрх зүйн мэдлэг олгож байх нь зүйтэй.

Мөн “Гэр бүлийн тухай” хуульд хамтран амьдрагчдын талаар тодорхой заалт оруулах шаардлагатай. Ингэснээр “Гэр бүлийн тухай” хууль болон “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хууль хоорондын уялдаа холбоог хангах, нөгөө талаараа хамтран амьдрагчдын өмнө тулгарсан олон асуудлуудыг шийдвэрлэх эрх зүй орчныг бий болгох юм.

Цаашилбал, энэхүү асуудлыг нарийн хуульчлаагүйн улмаас шүүхийн шатанд хамтран амьдрагчдын харилцааг шийдвэрлэхэд хүндрэл гардаг. Мөн түүнчлэн хамтран амьдрагчид салах асуудлаар шүүхэд хандах боломжгүй ч тэдний салалтыг даган гарах хүүхдийн асрамж, тэтгэвэр тэтгэмж, хөрөнгийн маргааныг шийдвэрлэх практик шаардлага байдаг.

Хамтран амьдрагчийн талаарх гадаад орнуудын эрх зүйн зохицуулалт

Нэг. ЭСТОНИ УЛС

Хамтын амьдралын тухай хууль (Cohabitation Act)⁴⁷ нь 4 бүлэг 26 зүйл заалттай бөгөөд гэрлэх зорилгогүй хамтран амьдрах эсхүл гэрлэх боломжгүй (ижил хүйстэн хосууд) хамтын амьдралтай хүмүүсийн гэр бүлийн шинжтэй харилцааг зохицуулж, тэдэнд зохих эрх зүйн хамгаалалтыг бий болгох гол зорилготой. Гэрлэлтээ батлуулахгүйгээр хамтран амьдарч байгаа хосууд бүртгүүлэхийн тулд хамтран амьдрах гэрээ байгуулсан байх шаардлагатай ба Гэр бүлийн тухай хуульд заасан эхнэр, нөхрийн эрх, үүргийг хүлээнэ.

Хоёр. ИРЛАНД УЛС

Хамтран амьдрагч хосуудын эрхийг 2010 оны Хамтран амьдрагчдын эрх, үүргийн тухай хуульд (Civil Partnership and Certain Rights and Obligations of Cohabitants Act 2010) заасан байдаг.⁴⁸ Энэ хуулийн дагуу хамтран амьдрагч хосууд нь харилцан дотно, тууштай харилцаатай амьдарч буй эсрэг болон ижил хүйстэн хүмүүсийг хэлнэ.

Эдгээр хамтран амьдарч буй хосууд өв залгамжлал, тэжээн тэтгэх, өмч хөрөнгө, хүүхдийн асран хамгаалагч, үрчлэн авах зэрэг эрх эдэлдэг. Мөн хамтран

амьдрагчийн гэрээ байгуулахыг зөвлөдөг бөгөөд салсан тохиолдолд дундаас бий болсон хөрөнгийг шүүх гэрээний нөхцөлөөс хамааран шийдэх ба гэрээнд аль нэг тал давуу болон сул тал давамгайлсан бол гэрээг хүчингүйд тооцож шүүх шийдвэрлэдэг байна.

Дүгнэлт, санал

Судалсан гадны орны жишгийг авч үзвэл, хамтран амьдрагчийн эрх, үүргийг бие даасан хуулиар зохицуулдаг бөгөөд тэдгээрийн эрх, үүргийг гэр бүлийн харилцаатай адил байдлаар хүлээн зөвшөөрч, хосуудын эрх, үүрэг, хүүхэд үрчлэн авах, тэжээн тэтгэх харилцаа, өв залгамжлал зэрэг асуудлуудыг зохицуулдаг байна.

Иймд, Монгол Улс хамтран амьдрагчийг “гэр бүл”-ийн нэгэн хэлбэрээр хүлээн зөвшөөрч холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх, тухайлбал тодорхой хугацаанд хамтран амьдарсан, дундаасаа хүүхэдтэй болсон, дундын өмч хөрөнгө үүссэн тохиолдолд “гэрлэлтийн гэрээ”-гээр шийдвэрлэх хэрэгцээ, шаардлагатай байна.

Мөн хамтран амьдрагч байсан эцэг, эх салж тусдаа амьдрах тохиолдолд хүүхдийн асрамж, тэтгэмжийг тогтоохдоо нийтлэг зарчмыг баримтлах ёстой.

IV. Дүгнэлт

Нийгмийн анхдагч нэгж болох гэр бүлийн харилцлаа тогтвортой байснаар тухайн улсын нийгмийн тогтвортой байдал хангагдана. Иймд төрөөс гэр бүлийн харилцаа, нийгэмшлийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ чухал ач холбогдолтой.

Монгол улсад Гэр бүлийн тухай хууль 1999 онд батлагдсанаас хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь шинээр үүсэж буй гэр бүлийн харилцааг зохицуулахад хязгаарлагдмал байна.

Өөрөөр хэлбэл, гэр бүлийн харилцаан дахь шинээр тогтож буй гэр бүлийн хэлбэр (хамтран амьдрагч), тээгч эхийн тусламжтайгаар хүүхэдтэй болох жам ёсны болон эдийн засгийн харилцаа, удмын сангийн аюулгүй байдлыг хангах гэх мэт харилцааг бүрэн зохицуулж чадахгүй байгаа тул тус хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай.

Дээрх хэрэгцээ, шаардлагад үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна.

- Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуульд заасан хүний эрх, гэр бүлийн гишүүдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тухайлбал Хүүхдийн эрхийн конвенцын дагуу хүлээсэн хүүхдийн эрхийг дээд зэргээр хангах төрийн үүрэг заавал биелэгдэх нөхцөлийг баталгаажуулах;

- Гэр бүлийн харилцаатай холбоотой Монгол Улсын олон улсын гэрээ ба бусад хууль тогтоомжийн нийцлийг судалж, зөрчлийг тодруулсны үндсэн дээр олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ сахин биелүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

- Гэр бүлийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төсөл боловсруулахдаа гэр бүлийн эрх зүйн ерөнхий (ардчилсан ёсны; энэрэнгүй; шударга ёсны; хууль дээдлэх; эрх, үүргийн нэгдэлтэй байх; зөвхөн гэм буруугийн төлөө хариуцлага хүлээх; тэгш эрхийн зарчим) болон тусгай зарчим (гэр бүл нийгмийн үндсэн нэгж байх; гэрлэлт нь тэгш эрх, сайн дурын харилцаан дээр үндэслэх; нэг нөхөр, нэг эхнэртэй байх; гэр бүл, эх нялхас, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг төр хамгаалах; хүүхдийн эрх, ашиг сонирхлыг дээд зэргээр хамгаалах зэрэг зарчим)-ыг хангах;

- Гэр бүлийн харилцаанаас үүдэлтэй иргэний хэрэг, маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зөвхөн тухайн хувь хүний асуудал гэхээс

илүүтэйгээр улс орны нийгмийн суурь бүтэц болох гэр бүлийн тогтвортой байдлыг хадгалах, хамгаалах тал дээр шүүх байгууллагын оролцоог бүрдүүлэх, тухайлбал гэр бүл цуцлалтын асуудалд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг үр дүнтэй явуулах, шүүхийн шатанд “гэр бүлийг эвлэрүүлэх”-д чиглэсэн боломжит хувилбар бүхий процессыг тусгах зэрэг зөвлөмж багтсан болно.

Дээрх саналыг үндэслэн судалгааны дэд сэдэв бүрээр нарийвчлан дүгнэвэл:

Нэг. Гэр бүл дуусгавар болсны дараа эцэг, эх хүүхдэдээ олгох тэтгэмжийг тогтоохдоо нийтлэг байдлаар бус тухайн эцэг, эхийн эдийн засгийн чадавхад тааруулан тогтоох нь зүйтэй. Энэ нь хүүхдийн тэтгэмж авах эрхийг хангах бодит хэрэглүүр болно гэж үзлээ.

Хоёр. Хүн амын удмын сангийн аюулгүй байдал ба гэрлэх нөхцөлийг зохицуулахдаа удмын санд аюул учруулаад буй цус ойртолтын шалтгааныг харгалзан шийдвэрлэх нь уг харилцааг ГБТХ-иар зохицуулснаар илүү үр дүнд хүрнэ. Харин гэрлэхэд харшлах нөхцөлийг хуульд тусгахдаа “төрөл садан” гэх мэт нийтлэг нэр томъёоноос илүүтэйгээр “ургийн хэдэн үе доторх” гэх мэтээр нарийвчлах хэрэгтэй.

Гурав. Донор, тээгч эхийн харилцааг холбогдох журмаар зохицуулах нь эрх зүйн тогтворгүй байдлыг үүсгэх эрсдэлтэй тул тэдний эрх, үүргийг хуулиар зохицуулах ёстой.

Дөрөв. Гэрлэгчид гэрлэлтийн гэрээ байгуулахдаа эд хөрөнгийн маргаан шийдвэрлүүлэхэд илүүтэй ач холбогдол өгч буй нь судалгаанаас ажиглагдлаа. Гадны зарим орны гэрлэлтийн гэрээний загварыг харвал эдийн бус харилцааг гэрээнд тусгах хандлага их буйг харгалзан гэрлэгчид гэр бүл цуцлах тохиолдолд хүүхдийн асрамжийн асуудал, биесээ харилцан асрах гэх мэт эдийн бус харилааг гэрээнд тусгах хандлагыг төлөвшүүлэх нь зүйтэй.

Тав. Сүүлийн үед манай улсад хамтран амьдрагчдын тоо өсч байгааг анхаарч хамтран амьдрагчдын харилцааг гэр бүлийн харилцаа талаас зохицуулах, дундын өмч, хүүхдийн асрамжийн асуудлыг гэрлэлтийн гэрээгээр шийдвэрлэх боломж байгаа эсэхийг судлах хэрэгтэй.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль /1992/
2. Гэр бүлийн тухай хууль /1999/
3. Иргэний хууль /2002/
4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /2002/
5. Хүүхдийн эрхийн тухай конвенц
6. Донорын тухай хууль /2018/
7. Эрүүл мэндийн сайдын А/500 дугаар тушаалаар батлагдсан “Донор бэлгийн эс ашиглах, үр хөврөл шилжүүлэн суулгах журам /2018/
8. Украин улсын Гэр бүлийн тухай хууль /2002/
9. БНСУ-ын Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /1991/
10. ХБНГУ-ын Иргэний тухай хууль /2002/
11. ХБНГУ-ын Эрүүгийн хууль
12. Норвегийн Эцэг Эхийн Хариуцлагын тухай хууль
13. ОХУ-ын Гэр бүлийн тухай хууль 1995
14. Турк улсын иргэний тухай хууль 2001
15. Их британ улсын хүүхдийн тухай хууль 1989

Ном, сэтгүүл:

1. А.Гидденс, Социологи
2. Үндэсний статистикийн хороо. Өрх, гэр бүлийн байдал, гэрлэлт сэдэвт судалгааны тайлан, Улаанбаатар: 2010.
3. ШУА-ийн ФСХ, УБИС. Монголын гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, Улаанбаатар: 2010.
4. Улсын их хурлын Тамгын газрын судалгааны эмхэтгэл XXIV боть. Монгол улсын хүн амын удмын сангийн аюулгүй байдал, бусад орнуудын туршлага, Улаанбаатар 2017 он
5. Парламантын судалгаа, сургалтын хүрээлэнгийн судалгааны эмхэтгэл 39 боть. Гэр бүл салалт, гэр бүлийн харилцааны зөрчил шийдвэрлэлтийн талаарх бусад орнуудын туршлага ба Монгол Улсын нөхцөл байдал (СТ-22/215), Улаанбаатар 2022 он

6. Улсын их хурлын Тамгын газрын судалгааны эмхэтгэл XXI боть. Хүүхэд асран хамгаалах эцэг, эхийн хариуцлагын тухай Монгол Улсын болон гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт, туршлага (Харьцуулсан судалгаа), Улаанбаатар 2015 он
7. Парламантын судалгаа, сургалтын хүрээлэнгийн судалгааны эмхэтгэл XXXII боть. Удмын сангийн бодлого, түүнийг хамгаалах, зохицуулахтай холбогдсон эрх зүйн бартимт бичгийн харьцуулсан судалгаа, Улаанбаатар 2021 он
8. Парламантын судалгаа, сургалтын хүрээлэнгийн судалгааны эмхэтгэл XXXII боть. Гэр бүлийн харилцааны эрх зүйн зохицуулалтын зарим асуудал: бусад орнуудын туршлага, Улаанбаатар 2021 он
9. Гэр бүлийн дундын эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалт О.Отгонтуяагийн Хууль зүйн докторын зэрэг горилсон бүлээл, Улаанбаатар 2022 он
10. Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхим. Судалгааны илтгэлийн эмхэтгэл. Улаанбаатар 2006 он
11. Улсын их хурлын Тамгын газрын судалгааны эмхэтгэл XXIV боть. Тээгч эх ба тээгч эхээр хүүхэд тээлгэж төрүүлэх харилцааны талаарх Монгол Улс болон гадаад орнуудын туршлага, эрх зүйн зохицуулалт, Улаанбаатар 2017 он
12. С.Нарангэрэл, “Хууль зүйн нэвтэрхий толь бичиг”, Улаанбаатар 2021 он,
13. Ц.Амарсанаа, Хүний удмын сан буюу генетикийн хууль зүйн асуудал, /илтгэл/
14. Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ /судалгааны тайлан/
15. Монгол гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт. Судалгааны тайлан. Улаанбаатар 2019 он
16. Доктор Б. Оюун-Эрдэнэ., Гэр бүлийн судалгаа боловсролын хүрээлэн, Монгол гэр бүлийн бүтэц хэв маяг, харилцааны онцлог, тулгамдаж буй асуудал сэдэвт судалгаа.

17. Э.Энхмаа, Монголын хүн амын генетик тогтоц, ур амьсгалын хахиршилт ба өвчлөл, нас баралтын хам холбоог газар зүйн байршлаар мөгшин судлах, Улаанбаатар хот, 2010 он.
18. Цус ойртолт ба окуны хомсдол Монгол улсын хэмжээнд /судалгааны тайлан/ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны захиалгат судалгаа Улаанбаатар 2020 он
19. О.Отгонтуяа, О.Амарсайхан. “Монгол улсын гэр бүлийн хууль, түүний хэрэгжилт” Улаанбаатар 2009 он
20. Төрийн мэдээлэл, тусгай дугаар, 1-р боть, 2004 он,

Цахим эх сурвалж:

1. <https://legalinfo.mn/mn/detail/15406>
2. <http://www.mglnews.mn/content/read/58246.htm>
3. <http://www.tusgal.mn/teegch-ekh-ba-eruul-mend-ami-nas-yos-surtakhuunaaraa-biznes-khiideg-yaduu-azi-busguichuud>
4. <https://www.riigiteataja.ee/en/eli/527112014001/>
5. <https://www.irishstatutebook.ie/eli/2010/act/24/enacted/en/html>
6. <https://cis-legislation.com/document.fwx?rgn=1809>
7. <https://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/84956/94847/F1253520391/EST-84956.pdf> (сүүлд үзсэн: 12.31нд)
8. <https://www.abc.net.au/cm/lb/4093556/data/family-law-act-1975-data.pdf>